# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 18 (447)

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- *Үндэсний хөтөлбөр батлах, түүнийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай*
- *Хамгаалалтын бүс тогтоох тухай*
- *Байгалийн бүсчлэлд хамрагдах сумдын нэрийн жагсаалт батлах тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар
Улаанбаатар хот
2006 он

# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Долоо хоног тутмын

Улаанбаатар хот | 2006 оны тавдугаар сарын 14 | №18 (447)

## Гарчиг

### МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ


| | | | |
|---|---|---|---|
| 241. | Үндэсний хөтөлбөр батлах, түүнийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай | Дугаар 64 | 497 |
| 242. | Ажлаас чөлөөлөх, ажилд томилох тухай | Дугаар 67 | 503 |
| 243. | Ажлаас чөлөөлөх, ажилд томилох тухай | Дугаар 68 | 504 |
| 244. | Хэлэлцээр батлах тухай | Дугаар 69 | 504 |
| 245. | Хамгаалалтын бүс тогтоох тухай | Дугаар 70 | 504 |
| 246. | Байгалийн бүсчлэлд хамрагдах сумдын нэрийн жагсаалт батлах тухай | Дугаар 71 | 505 |
| 247. | Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө (Засгийн газрын 2006 оны 57 дугаар тогтоолын хавсралтын үргэлжлэл) | | 510 |


## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

**2006 оны 4 дүгээр сарын 3-ны өдөр** | **Дугаар 64** | **Улаанбаатар хот**

### Үндэсний хөтөлбөр батлах, түүнийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай

Архивын тухай хуулийн 9.2.3-ыг үндэслэн архивын салбарт мэдээллийн технологи нэвтрүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх үндэсний хөтөлбөр"-ийг 1 дүгээр, хөтөлбөрийн эхний үе шатыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг (2006-2008 он) 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Архивын салбарт мэдээллийн технологи ашиглах, үүнтэй холбогдуулан судалгаа, төсөл хэрэгжүүлэн, архивын мэдээллийн сан бүрдүүлэх, төрийн байгууллагуудын албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг автоматжуулахад шаардагдах зардлын эх үүсвэрийг жил бүрийн төсвийн багцад багтаан санхүүжүүлэх арга хэмжээ авахыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт үүрэг болгосугай.

3. Архивын салбарт мөрдөгдөж байгаа журам, заавар, стандартыг төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх үндэсний хөтөлбөрт нийцүүлэн 2006-2007 онд багтаан шинэчлэн боловсруулж мөрдүүлэх арга хэмжээ авахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Д.Одбаяр, Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн газрын дарга Ч.Сайханбилэг нарт тус тус даалгасугай.

4. Архивын автоматжуулалт, цахим бичлэгийн чиглэлээр олон улсын архивын арга туршлагыг судалж, олон улсын архивын байгууллагатай хамтран ажиллах, техникийн зөвлөгөө, туслалцаа авах арга хэмжээг 2006 онд багтаан шуурхай зохион байгуулахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Д.Одбаяр, Гадаад хэргийн сайд Н.Энхболд, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Ө.Энхтүвшин нарт даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД** — **М.ЭНХБОЛД**

**ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД** — **Д.ОДБАЯР**

*Засгийн газрын 2006 оны 64 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт*

# ТӨРИЙН АРХИВ, АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ НЭВТРҮҮЛЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

**Нэг. Хөтөлбөр боловсруулах үндэслэл, шаардлага**

Төрийн архив нь тухайн улс үндэстний түүхэн ой санамж бөгөөд энэ утгаараа архивын баримт бол нийгмийн үнэт баялаг төдийгүй мэдээллийн чухал нөөц, эх сурвалж гэдгийг өнөөдөр олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрч байна. Үүнтэй холбоотойгоор мэдээллийн технологи асар их хөгжсөн эрин үед төрийн архивын нэг үндсэн үүрэг нь сан хөмрөгтөө хадгалагдаж буй түүхэн баримтыг улс, нийгмийн болон эрдэм шинжилгээ, судалгааны зорилгод өргөн хүрээтэй ашиглуулж, байгууллага, иргэдэд архивын мэдээллээр шуурхай үйлчлэх явдал юм.

Нийгэм-эдийн засгийн гүн гүнзгий өөрчлөлт, үндэсний түүх, соёлоо сэргээн хөгжүүлэх төрийн бодлого, зорилттой уялдан төрийн архивын баримт, материалыг судлах, үзэж ашиглах нийгмийн эрэлт хэрэгцээ, шаардлага тасралтгүй өсч байна. Гэвч төрийн архивуудын өнөөгийн үйл ажиллагаанаас үзэхэд архивын баримтын ашиглалт хангалтгүй, архивын мэдээллийг байгууллага, иргэд элж авах боломжгүй байгаа нь төрийн аль ч архивт мэдээлэл-эрэлт хайлтын үйл ажиллагаа боловсронгуй бус, төрийн архивуудад орчин үеийн мэдээллийн технологи нэвтрээгүй байгаатай холбоотой юм.

Баримт бичиг, мэдээллийн урсгал нэмэгдэж байгаатай уялдан баримт, мэдээллийг цахим хэлбэрээр хөтөлж, тэдгээрийг зөв зохистой журамлах, зохицуулах, архивлан хадгалах асуудал нь тулгамдсан зорилт болж байна. Ардчилал, зах зээлийн нөхцөлд төрийн үйлчилгээ, бизнесийн үйл ажиллагаа зохион байгуулалттай, шуурхай явагдах ёстойбөгөөд түүний угтвар нөхцөл нь байгууллагын албан хэрэг хөтлөлтийг автоматжуулах, удирдлагын үйл ажиллагааны мэдээллийн орчинг боловсронгуй болгох явдал юм.

Өнөөдрийн байдлаар төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх үйл явц эхлэл төдий, урсгал шинх байдалтай, нэгдсэн удирдлага, зохион байгуулалтгүй, энэ талаар олон улсын архивын байгууллагаас төдийгүй өөрийн орны бусад салбараас үлэмж хоцрогдонгуй байна.

Монгол Улсын Засгийн газар олон улсын архивын хөгжлийн чиг хандлага, манай орны архивын салбарын хэрэгцээ, шаардлагыг үндэслэн төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх асуудалд тэргүүлэх ач холбогдол өгөхийн зэрэгцээ хөрөнгө, хүн хүч, цаг хугацаа, техник, технологийн болон удирдлага, зохион байгуулалтын олон талт арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатайг харгалзан үндэсний хэмжээний хөтөлбөр боловсруулж, хэрэгжилтийг зохион байгуулах нь зүйтэй гэж үзэж байна.

**Хоёр. Төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэхэд тулгамдаж байгаа асуудал**

2.1. Бодлогын орчин

2.1.1. Архивын үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх асуудлыг зохицуулах эрх зүйн орчин боловсронгуй болоогүй тул энэ талаар баримтлах төрийн нэгдсэн бодлого, стратегийг тодорхой болгох шаардлагатай;

2.1.2. Архивын салбарт мэдээллийн технологи нэвтрүүлэх талаар цэгцтэй ойлголт байхгүй, энэ талаархи судалгаа, арга зүйн үйл ажиллагаа хангалтгүй байна.

2.2. Удирдлага, зохион байгуулалтын орчин

2.2.1. Салбарын хэмжээнд тухайн асуудлыг мэргэжлийн чиглэлээр хариуцсан бүтэц байхгүй;

2.2.2. Яам, агентлаг, төв болон орон нутгийн байгууллагын удирдлагын зүгээс архив, бичиг хэргийн ажилд дэмжлэг туслалцаа үзүүлэх, мэргэжлийн байгууллагатай ажиллах хамтын ажиллагаа сул;

2.2.3. Төрийн архив төсвөөс санхүүждэг боловч шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмж худалдан авах, программ хангамж боловсруулах зэрэг томоохон арга хэмжээний хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлэж байгаагүй;

2.2.4. Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааны чиглэлээр урт хугацааны төлөвлөгөө, хөтөлбөр хэрэгжиж байгаагүй;

2.2.5. Архив, албан хэрэг хөтлөлтийн чиглэлээр олон улсын санхүүгийн байгууллага, хандивлагч орнуудаас үзүүлж буй хөнгөлөлттэй зээл, техникийн тусламжид хамрагдаж байгаагүй.

2.3. Судалгаа, арга зүйн орчин

2.3.1. Архивын тоо бүртгэл, эрдэм шинжилгээ, лавлах мэдээллийн сан байгуулах үйл ажиллагаа хангалтгүй;

2.3.2. Архивын мэдээллийг ангилан төрөлжүүлэх, сэдэв агуулгаар тодорхойлон бичих, кодлоллах ажил удаашралтай;

2.3.3. Архивын сан хөмрөгийн агуулга, бүрэлдэхүүнийг тодорхойлсон хоёрдогч мэдээллийн сан байгуулах ажил эхлэлтийн шатанд байгаа;

2.3.4. Албан хэрэг хөтлөлтийн ажлын арга зүй, зохион байгуулалт боловсронгуй бус.

2.4. Удирдлага, хүний нөөц

2.4.1. Архивын салбарт хүний нөөцийн менежментийн бодлого алдагдсан;

2.4.2. Байгууллагын удирдлагын зүгээс бичиг хэргийн ажлын үүрэг, ач холбогдлыг дутуу үнэлж ирсэн;

2.4.3. Архивын салбарт мэргэжлийн боловсон хүчин, мэдээллийн технологийн чиглэлээр мэргэшсэн ажилтнууд цөөн;

2.4.4. Мэдээллийн технологийн чиглэлээр олон улсын архивын арга туршлагаас суралцах, судлах боломж хязгаарлагдмал зэрэг болно.

**Гурав. Хөтөлбөрийн зорилго, стратегийн зорилт**

3.1. Зорилго

Архивын салбарт техникийн шинэчлэл хийх, орчин үеийн мэдээллийн технологийн ололтыг өргөн ашиглах замаар архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг автоматжуулах зорилтыг үе шаттайгаар шийдвэрлэж, төрийн архивын мэдээллээр үйлчлэх боловсронгуй тогтолцоог бий болгоход хөтөлбөрийн зорилго оршино.

3.2. Стратегийн зорилт:

3.2.1. Мэдээлэлжсэн нийгэм байгуулах төрийн бодлогыг архивын салбарт хэрэгжүүлэх;

3.2.2. Төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх явдалд тэргүүлэх ач холбогдол өгч, эрх зүйн таатай орчин бүрдүүлэх;

3.2.3. Мэдээлэл, харилцаа холбооны технологид тулгуурласан архивын удирдлагын орчин үеийн загварыг бий болгох;

3.2.4. Мэдээлэлжсэн нийгэмд төрийн архивын гүйцэтгэх үүргийг дээшлүүлэх;

3.2.5. Мэдээллийн эрин зуунд түүх, архивын өвийг найдвартай бүрдүүлж, хадгалж хамгаалахад мэдээллийн технологийн боломжийг үр дүнтэй ашиглах;

3.2.6. Төрийн архивын тоо бүртгэл, мэдээлэл, эрэлт хайлтын цахим тогтолцоог бүрдүүлэх;

3.2.7. Байгууллагын албан хэрэг хөтлөлтийг автоматжуулах үндсэн дээр бичиг хэргийн эмх цэгц, зохион байгуулалтыг сайжруулж, технологийн шинэчлэл хийх;

3.2.8. Төрийн мэдээллийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх үгтвар нөхцөл болсон цахим бичиг хэргийн системийг байгууллага, салбарын үйл ажиллагаанд тууштай нэвтрүүлэх.

**Дөрөв. Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх үндсэн чиглэл**

4.1. Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологийг дараахь үндсэн чиглэлээр нэвтрүүлнэ. Үүнд:

1. Архивын баримтын тоо бүртгэл;
2. Архивын баримтын ашиглалт, эрэлт хайлт;
3. Архивын баримтын хадгалалт, хамгаалалт;
4. Архивын сан хөмрөгийн нөхөн бүрдүүлэлт, нягтлан шалгалт;
5. Архивын удирдлага, төлөвлөлт зохион байгуулалт;
6. Төрийн байгууллагын албан хэрэг хөтлөлт;
7. Архивын мэдээллийн нэгдсэн сүлжээ байгуулах.

4.1.1. Архивын баримтын тоо бүртгэл

Үндсэн агуулга: Төрийн архивт хадгалагдаж байгаа бүх баримтыг тоо бүртгэлд хамруулах, архивын сан хөмрөгийн бүрэлдэхүүн, тоо хэмжээнд орсон өөрчлөлт, хөдөлгөөн болон нэгдсэн мэдээ тайланг мэдээллийн технологийн тусламжтай үнэн зөв, хөнгөн шуурхай хөтлөн явуулах;

4.1.2. Архивын баримтын ашиглалт, эрэлт хайлт

Үндсэн агуулга: Төрийн архивт хадгалагдаж байгаа бүх баримтын агуулга, бүрэлдэхүүн, байршлыг харуулсан хоёрдогч мэдээллийн сан бүрдүүлж, мэдээллийг хайх автоматжуулсан систем бий болгох замаар архивын баримтад агуулагдсан мэдээллийг үр дүнтэй, шуурхай, хүртээмжтэй ашиглуулах нөхцөлийг бүрдүүлэх, архивын сан хөмрөгийн ашиглалтын талархи судалгаа, тайлан бүртгэлийг боловсронгуй болгох;

4.1.3. Архивын баримтын хадгалалт, хамгаалалт

Үндсэн агуулга: Архивын хосгүй үнэ үнэт болон эрэлт хэрэгцээ ихтэй, байнга ашиглагддаг баримтыг хамгаалалтын болон ашиглалтын ахим хувьтай болгох замаар эх баримтыг бүрэн бүтэн хадгалж, хойч үедээ өвлүүлэх, төрийн удирдах дээд байгууллагын үйл ажиллагааны холбогдолтой баримтыг тоон хэлбэрт оруулж, хадгалалтыг найдвартай, ашиглалтыг шуурхай болгох;

4.1.4. Төрийн архивын нөхөн бүрдүүлэлт, нягтлан шалгалт

Үндсэн агуулга: Автоматжуулсан горимоор төрийн архивын нөхөн бүрдүүлэх эх үүсвэрийн жагсаалт хөтлөх, төрийн архивт шилжүүлсэн баримтын нийт тоог гаргах, байгууллагын албан хэрэг хөтлөлт, архивын үйл ажиллагаанд хяналт тавих, мэдээ тайлан гаргах, баримт бичиг нягтлан шалгах комиссын үйл ажиллагааг нэгтгэн дүгнэх. Төрийн архивын баримтад нягтлан шалгалт хийж эрдэм шинжилгээ, техник боловсруулалтын ажлыг сайжруулсаар мэдээллийн автоматжуулсан систем бий болгох ажлын эхлэлийг тавих;

4.1.5. Архивын удирдлага, төлөвлөлт, зохион байгуулалт

Үндсэн агуулга: Төрийн архивын төлөвлөлт, тайлан бүртгэлийн холбогдолтой ажлд

автоматжуулсан технологийг нэвтрүүлж, төрийн архивын үйл ажиллагааны үр дүнг жил бүрийн 1 дүгээр сарын 1-ний байдлаар гаргах, мониторинг хийх, дараагийн шатны зорилтыг төлөвлөж тооцох бололцоо нөхцөлийг бүрдүүлэх;

4.1.6. Төрийн байгууллагын албан хэрэг хөтлөлт

Үндсэн агуулга: Удирдлагын үйл ажиллагаа баримтжуулах, баримт бичиг бүртгэх, тараах, шийдвэрлэлтэд нь хяналт тавих, албан хэрэг бүрдүүлэх зэрэг ажилбаруудыг автоматжуулах замаар баримт бичигтэй ажиллах ажлыг боловсронгуй болгон мэдээллийн сан байгуулах, сүлжээ /виртуал/-ний орчинд ажиллах, мэдээллийг цахим хэлбэрээр солилцох, төвлөрүүлэн хадгалах, шуурхай, хүртээмжтэй ашиглах нөхцөлийг бүрдүүлэх;

4.1.7. Архивын мэдээллийн нэгдсэн сүлжээ байгуулах

Үндсэн агуулга: Төрийн архивын баримтын агуулга, бүрэлдэхүүн, байршлын талаархи хоёрдогч мэдээллээр нэгдсэн сан байгуулж, байгууллага, иргэдэд цахим хэлбэрээр ашиглуулах боломжийг бүрдүүлэх.

**Тав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үе шат**

Хөтөлбөрийн зорилтыг дараахь 2 үе шаттай байхаар тодорхойлж байна. Үүнд:

1. Нэгдүгээр үе шат буюу 2006-2008 он /ойрын хугацаа/
2. Хоёрдугаар үе шат буюу 2009-2012 он /дунд хугацаа/

5.1. Нэгдүгээр үе шат /2006-2008 он/-нд хөтөлбөрийг хэрэгжүүлэх эрх зүйн орчин болон зохион байгуулалт, хүний нөөцийн чадавхийг бүрдүүлж, хөтөлбөр хэрэгжүүлэх арга технологийг эзэмших үндсэн дээр төрийн архивыг компьютержүүлэх, архив, албан хэрэг хөтлөлтийн ажлыг автоматжуулах үйл ажиллагааг эрчимтэй зохион байгуулна;

5.2. Хоёрдугаар үе шат /2009-2012/-нд төрийн архивын мэдээлэл, эрэлт хайлтын автоматжуулсан сан байгуулах, төрийн архивын мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, байгууллагын үйл ажиллагаанд цахим бичиг хэргийн тогтолцоог нэвтрүүлэх зорилтыг үндсэнд нь шийдвэрлэнэ.

**Зургаа. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны зарчим**

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд дараахь зарчмыг баримтална. Үүнд:

6.1. Хөтөлбөрийг нэгдсэн бодлого, арга зүйн үндсэн дээр системтэй, архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг боловсронгуй болгох замаар хэрэгжүүлэх;

6.2. Дотоод нөөц боломжоо бүрэн дүүрэн дайчлах, хөрөнгийн эх үүсвэрийг зөв зохистой зарцуулах;

6.3. Төрийн архивын уламжлалт арга, хэлбэр, зохион байгуулалттай нягт уялдсан, залгамж холбоотой байх;

6.4. Архивын мэдээлэл, эрэлт хайлтын программ хангамж нь өмнөх үед хуримтлагдсан мэдээллийг найдвартай хадгалах нөхцөлийг бүрдүүлсэн байх;

6.5. Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх программ хангамжууд нь стандарт, формат, өгөгдлүүдийн хувьд ижил загвартай байх.

**Долоо. Ойрын хугацааны хөгжлийн зорилт**

7.1. Архивын баримтын цахим мэдээллийн сан байгуулах, ашиглах талаар судалгаа явуулж, арга зүйн зөвлөмж, аргачлал боловсруулах;

7.2. Архивын баримтын ангиллын нэгдсэн бүдүүвч зохиох, түүний дагуу архивын баримтыг тодорхойлон бичих, ангилан төрөлжүүлэх, кодлох;

7.3. Төрийн архивын баримтад эрдэм шинжилгээ-техник боловсруулалт хийсэн байдлыг нягтлан шалгаж, данс бүртгэлийг шинэчлэн сайжруулах, цахим хэлбэрт оруулах арга хэмжээ авах;

7.4. Мэдээллийн эрэлт хэрэгцээ ихтэй архивын хөмрөгүүдэд сэдэвчилсэн боловсруулалт хийж, архивын хоёрдогч мэдээллийн сан бүрдүүлэх ажлыг зохион байгуулах;

7.5. Төрийн архивын тоо бүртгэл, мэдээлэл, эрэлт хайлт, байгууллагын албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг автоматжуулах программ хангамж боловсруулах, турших, нэвтрүүлэх үйл ажиллагааг дэмжих, хөгжүүлэх;

7.6. Мэдээллийн технологийн тусламжтайгаар архивын эрдэм шинжилгээний лавлах бичгүүдийг бэлтгэх ажлыг өргөн хүрээтэй зохион байгуулах;

7.7. Албан хэрэг хөтлөлтийн программ хангамжийн стандартын хэрэглээг бий болгон, цахим бичиг хэргийн тогтолцоог тодорхой байгууллага, салбарын хэмжээнд нэвтрүүлэх;

7.8. "Цахим Монгол" хөтөлбөрт заасны дагуу албан хэрэг хөтлөлтийг цахим хэлбэрт оруулах зохион байгуулалтын арга хэмжээ авах.

**Найм. Дунд хугацааны хөгжлийн зорилт**

8.1. Архивын хоёрдогч мэдээллийг зохих программ хангамжийн үндсэн дээр мэдээллийн санд бүрэн оруулах;

8.2. Төрийн архивын сан хөмрөгийн үндсэн хэсгийн баримтыг олон улсын стандартын дагуу тодорхойлж, сэдэв, асуудлаар эрж хайх боломжийг бүрдүүлэх зорилгоор архивын мэдээллийн автоматжуулсан сан байгуулах;

8.3. Архивын лавлах бичгүүдийг цахим хэлбэрт оруулж, электрон каталог, өгөгдлийн сангууд байгуулах, олон нийт чөлөөтэй ашиглах, зайнаас хандах боломж бүрдүүлэх;

8.4. Төрийн архивын сан хөмрөгийн талаархи мэдээлэл-лавлагааг онлайн хэлбэрээр

авах нөхцөлийг хангах;

8.5. Архивын баримтаар сэдэвчилсэн болон хүний нэрийн цахим сангууд байгуулах;

8.6. Тусгай төрлийн баримтын (кино, дуу, дүрсний болон шинжлэх ухаан, технологийн) цахим хувийг үйлдэж, хадгалалт, ашиглалтыг сайжруулах арга хэмжээ авах;

8.7. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газрын үйл ажиллагааны үндсэн баримт бичгийг цахим хэлбэрт оруулах, хадгалах, ашиглах ажлыг зохион байгуулах;

8.8. Төрийн байгууллагуудад баримт, мэдээллээ сүлжээгээр солилцох, электрон хэлбэрээр хадгалах боломжийг бүрдүүлэх.

**Ес. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт, санхүүжилт**

9.1. Удирдлага, зохион байгуулалт

9.1.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийг улсын хэмжээнд зохион байгуулах, хэрэгжилтэд нь хяналт тавих үүргийг Архивын зохицуулах Зөвлөл хэрэгжүүлнэ.

9.1.2. Архивын зохицуулах Зөвлөлийн дарга нь Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн сайд байх бөгөөд бүрэлдэхүүнд нь Үндэсний архивын газрын дарга, Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн газрын дарга, яамдын Төрийн захиргаа, удирдлагын газрын дарга орно.

9.2. Хөтөлбөрийн санхүүжилт

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг дараахь эх үүсвэрээс бүрдүүлнэ:

9.2.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалт;

9.2.2. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт;

9.2.3. Хандивлагч орон, олон улсын байгууллагын зээл, техникийн болон буцалтгүй тусламж, хандивын хөрөнгө;

9.2.4. Гадаад, дотоодын байгууллага, аж ахуйн нэгжийн хөрөнгө, хандив, буцалтгүй тусламж;

9.2.5. Бусад

**Арав. Хөтөлбөрийг дэмжих бодлого, арга хэмжээ**

10.1. Эрх зүйн орчин бүрдүүлэх

10.1.1. Архивын тухай хууль, Төрийн архивын ажлын үндсэн заавар, Албан хэрэг хөтлөлтийн зааварт холбогдох нэмэлт, өөрчлөлт оруулах;

10.1.2. Архивын сан хөмрөгийн баримтын нэгдсэн ангиллын схем боловсруулж, тэдгээрийг агуулга, сэдвээр тодорхойлон бичих зөвлөмж, аргачлалыг олон улсын архивын стандартад нийцүүлэн боловсруулах;

10.1.3. Цахим бичиг хэргийн тогтолцоог бүрдүүлэх, эрх зүйн орчинг бий болгох, холбогдох журам, заавар, стандарт, аргачлалыг боловсруулж, мөрдүүлэх;

10.1.4. Цахим бичлэгийг архивлан хадгалах, ашиглах, нууцлалыг хангах талаар зохих журам гаргаж, мөрдүүлэх.

10.2. Хөтөлбөрийг дэмжих үйл ажиллагаа

10.2.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг жил бүрийн улсын болон орон нутгийн төсөвт тусган хэрэгжүүлэх, олон улсын санхүүгийн байгууллага, хандивлагч орнуудаас олгож байгаа урт хугацааны хөнгөлөлттэй зээл, техникийн тусламжийг түлхүү ашиглах бодлого баримтлан хөтөлбөрийн зорилтыг хэрэгжүүлэх хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэх талаар шаардлагатай арга хэмжээ авах;

10.2.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх мэргэжлийн болон салбар дундын удирдлагын чадавхи, зохион байгуулалтын оновчтой хэлбэрийг бий болгох, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн төрийн байгууллагуудын үйл ажиллагааг дэмжих, уялдуулан зохицуулах;

10.2.3. Хөтөлбөрийн үе шат бүрээр тусгагдсан зорилтуудыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг нэгдсэн журмаар зохион байгуулах;

10.2.4. Архив, албан хэрэг хөтлөлтийн салбарт мэдээллийн технологи нэвтрүүлэхтэй холбогдуулж Үндэсний архивын газар, төрийн архивуудын бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох арга хэмжээ авах;

10.2.5. Хөтөлбөрийн хэрэгжилтэд төрийн архив, байгууллагын архив, бичиг хэргийн ажилтнуудыг жигд оролцуулах;

10.2.6. Яам, агентлагийн болон аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын бичиг хэргийн ажлын удирдлага, зохион байгуулалтыг сайжруулж, бусад газар, хэлтсүүдийн үйл ажиллагаатай зөв зохистой уялдуулах, мэдээлэл-технологийн чиглэлээр бэхжүүлэх;

10.2.7. Хөтөлбөрийн хүрээнд эрдэм шинжилгээ, судалгаа, төслийн ажил гүйцэтгэх, архивын хөмрөгийн баримтыг зүйлчлэх, архивын хоёрдогч мэдээллийн сан байгуулах арга хэмжээний зардлыг төсвийн ерөнхийлөн захирагчдын жил бүрийн төсвийн багцад тусган санхүүжүүлэх арга хэмжээ авах;

10.2.8. Төрийн байгууллагын албан хэрэг хөтлөлт хариуцсан ажилтанд мэдээлэл, харилцаа холбооны технологи ашиглах асуудлаар зөвлөгөө өгөх тогтолцоо бий болгох, дэмжиж ажиллах;

10.2.9. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зориулж гадаад, дотоодын иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас өгсөн хандив болон бусад эх үүсвэрээр хуримтлагдсан хөрөнгөөр төсвийн тусгай данс нээх.

10.3. Дэд бүтцийг хөгжүүлэх

10.3.1. Архив, бичиг хэргийн программ хангамж, түүний эрэлт хэрэгцээ, зах зээлийн талаар судалгаа явуулж сонголт хийх;

10.3.2. Төрийн архивуудыг өндөр

хүчин чадал бүхий компьютер, дагалдах хэрэгслээр хангах арга хэмжээ авах;

10.3.3. Үндэсний төв архив болон түүний салбар архивуудыг мэдээллийн нэгдсэн сүлжээнд хамруулах.

10.4. Судалгаа, сургалт, зөвлөгөө

10.4.1. Төрийн байгууллагуудын албан хэрэг хөтлөлтийн өнөөгийн төлөв байдалд харьцуулсан судалгаа хийх;

10.4.2. Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээлэл, харилцаа холбооны технологи ашиглах асуудлаар эрдэм шинжилгээ, судалгаа туршилтын ажлыг өргөтгөх;

10.4.3. Архив зүй, албан хэрэг хөтлөлтийн чиглэлээр үндэсний боловсон хүчнийг дотоод, гадаадын их, дээд сургуулиудад системтэйгээр бэлтгэх, архивын салбарт ажиллах мэдээллийн технологийн мэргэжилтнүүдийг өндөр хөгжилтэй орнуудад явуулж сургах, мэргэжлийг нь дээшлүүлэх;

10.4.4. Гадаад орнуудад хөтөлбөрийг сурталчилж, олон улсын дэмжлэг авах чиглэлээр ажиллах, архивын салбарт хамтран ажиллах гэрээ, хэлэлцээр, төслийн баримт бичгүүдэд мэдээллийн технологи нэвтрүүлэх, ашиглах талаар тусгах;

10.4.5. Мэдээллийн технологийг цахим бичлэгийн чиглэлээр ашиглан гадаад орнуудын архивын туршлага судлах, мэргэжилтэн урьж ажиллуулах.

## Арван нэг. Гарах үр дүн, түүнийг тайлагнах

11.1. Хүлээгдэж буй үр дүн

Төрийн архивын үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлснээр Монгол Улсын Засгийн газрын 2004-2008 оны үйл ажиллагааны хөтөлбөр, "Цахим Монгол" хөтөлбөрийн холбогдох заалтуудыг хэрэгжүүлэх боломж бий болж, дараахь үр дүнд хүрнэ.

11.1.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад төрийн архивын мэдээллийн нэгдсэн тогтолцоо бүрэлдэн, төрийн байгууллага, архивуудын хооронд мэдээлэл солилцох боломж бий болж, архив, албан хэрэг хөтлөлтийн ажлын бүтээмж, үр нөлөө дээшилж, төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд технологийн дэвшил нэвтэрнэ;

11.1.2. Олон улсын архивын мэдээллийн орон зайд нэгдэн орох эхлэл тавигдаж, бусад улсын архивуудтай мэдээлэл солилцох өргөн боломж нээгдэнэ;

11.1.3. Төрийн архивын мэдээлэл, эрэлт хайлтын үйл ажиллагаа чанарын шинэ шатанд гарна;

11.1.4. Монгол Улсын үндэсний архивын сан хөмрөгийн баримтын тоо хэмжээ, бүрэлдэхүүн, байршлын тухай мэдээллийг цахим хэлбэрээр авах боломж бий болж архив нээлттэй, хүртээмжтэй байж, иргэдэд үзүүлэх үйлчилгээ шуурхай болно;

11.1.5. Албан хэрэг хөтлөлтийг автоматжуулснаар бичиг хэргийн ажлын эмх цэгц, зохион байгуулалт сайжирч, баримт бичгийн шийдвэрлэлтэд шуурхай хяналт тавих боломж бүрдэнэ;

11.1.6. Архивыг судлах, сонирхох олон нийтийн хэрэгцээ өсөн нэмэгдэж, төрийн архивын ашиглалт бүх талаар сайжирна;

11.1.7. Багаараа баримт бичиг дээр ажиллах, сүлжээний орчинд асуудлыг хянан шийдвэрлэх, байгууллага, салбарын хэмжээнд баримт, мэдээллийг шуурхай дамжуулах, солилцох, өгөгдлийн сан үүсгэн ашиглах боломж бүрдэнэ;

11.1.8. Байгууллагын удирдлага тодорхой мэдээллийг байнга авч, ажил хэргийг жигд, шуурхай явуулах боломжтой болж, байгууллагын бичиг хэрэг, техникийн зардал багасна;

11.1.9. Байгууллага үйл ажиллагааныхаа явцад үүссэн зарим нэр төрлийн баримтаа электрон байдлаар архивлан найдвартай хадгалах, ашиглах нөхцөл бүрдэнэ;

11.1.10. Албан хэрэг хөтлөлтийг автоматжуулснаар төрийн байгууллагын ажилтнуудын үүрэг хариуцлага дээшилж, ил тод, шуурхай, соёлтой ажиллах боломж бүрдэнэ.

11.2. Хөтөлбөрийн үр дүнг тайлагнах

Хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг хууль зүй, дотоод хэргийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хөтөлбөрийн үе шат бүрээр гаргаж, Засгийн газарт танилцуулж байна.

*Засгийн газрын 2006 оны 64 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт*

## ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ЭХНИЙ ҮЕ ШАТНЫ ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ (2006-2008 он)

| № | Гүйцэтгэх ажил | Гүйцэтгэх хугацаа | Хариуцагч байгууллага |
|---|---|---|---|
| 1 | Хөтөлбөр хэрэгжүүлэх ажлыг хэрэгжүүлэх зорилгоор Үндэсний зөвлөл байгуулах | 2006 оны II-III улирал | ХЗДХЯ, СЯ |
| 2 | Архивын салбарт мэдээллийн технологийн чиглэлээр чадварлаг баг бүрдүүлэх | 2006 оны II-III улирал | ХЗДХЯ, Сангийн яам, УАГ |
| 3 | Төрийн архивын бие даасан вэб сайтыг байгуулж, тогтмол үйл ажиллагааг хангах | Байнга | ХЗДХЯ, УАГ, МХХТГ |

| | | | |
|---|---|---|---|
| 4 | Хөтөлбөрийг хэрэгжүүлэх нэгдсэн стратеги, үзэл баримтлал, үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах | 2006-2007 | ХЗДХЯ, ЗГХЭГ, ҮАГ, МХХТГ |
| 5 | Төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх асуудлаар холбогдох журам, заавар, аргачлал, стандарт боловсруулж, мөрдүүлэх | 2006-2007 | ХЗДХЯ, ЗГХЭГ, МХХТГ, СХЗТ |
| 6 | Архивын мэдээлэл, эрэлт хайлт, цахим бичиг хэргийн программ хангамж боловсруулж, турших, нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах | Байнга | ХЗДХЯ, ҮАГ, МХХТГ |
| 7 | Төрийн архивуудыг компьютержүүлэх ажлыг тодорхой судалгаа, тооцооны дагуу эхлүүлэх | 2006-2007 | ХЗДХЯ, ҮАГ, МХХТГ |
| 8 | Хөтөлбөрийг гадаад улс оронд сурталчлах зорилгоор Олон улсын архивчдын зөвлөлийн "Зүүн Азийн бүсийн салбар"-ын зөвлөгөөнийг Монгол Улсад зохион байгуулах | 2006 III улирал | ХЗДХЯ, ҮАГ, ШУА |
| 9 | Хөтөлбөрт хамрагдах байгууллага, төрийн албан хаагчдын дунд сэдэвчилсэн сургалт зохион байгуулах | 2006-2007 | ЗГХЭГ, ҮАГ |
| 10 | Төрийн архивын сан хөмрөгийн талаархи лавлах-танилцуулгыг бэлтгэж хэвлүүлэх | 2006-2007 | ҮАГ, ШУА |
| 11 | Мэдээллийн эрэлт хэрэгцээ ихтэй архивын томоохон хөмрөгүүдэд сэдэвчилсэн боловсруулалт хийж, архивын хоёрдогч мэдээллийн сан байгуулах, архивын данс бүртгэлийг цахим хэлбэрт оруулах бэлтгэл ажлыг эхлүүлэх | 2006-2007 | ҮАГ, ШУА, МХХТГ, аймаг, нийслэлийн ЗДТГ |
| 12 | Цахим бичиг хэргийн тогтолцоог тодорхой байгууллага, салбарын хэмжээнд нэвтрүүлж эхлэх | 2006-2008 | ХЗДХЯ, МХХТГ, ЗГХЭГ |
| 13 | Төрийн архив, албан хэрэг хөтлөлт хариуцсан ажилтнуудыг бэлтгэх нэгдсэн тогтолцоо бий болгох арга хэмжээ авах | 2007 | ХЗДХЯ, Сангийн яам, БСШУЯ |
| 14 | Төрийн архив, албан хэрэг хөтлөлт хариуцсан ажилтнуудыг гадаад, дотоодын урт, богино хугацааны сургалтад хамруулах | Байнга | ХЗДХЯ, Сангийн яам, БСШУЯ, ҮАГ |
| 15 | Улсын төсөв, гадаад орнуудын санхүүжилтээр хэрэгжүүлэх томоохон төсөл, арга хэмжээг тендер зарлан гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, санхүүжүүлэх | 2007-2008 | ХЗДХЯ, Сангийн яам, МХХТГ |
| 16 | ОХУ, БНСУ, Малайз зэрэг орнуудад хэрэгжүүлж буй ижил төстэй туршлагыг судалж, нэвтрүүлэх | Байнга | ХЗДХЯ, ЗГХЭГ, ГХЯ, СЯ |

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

**2006 оны 4 дүгээр сарын 5–ны өдөр** | **Дугаар 67** | **Улаанбаатар хот**

**Ажлаас чөлөөлөх, ажилд томилох тухай**

Засгийн газрын тухай хуулийн 18[3] дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Төрийн албаны зөвлөлийн 2006 оны 5 дугаар тогтоолыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Түр томилсон хугацаа нь дуусгавар болсонтой холбогдуулан Минжүүрийн Далайхүүг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Цаг уур, орчны шинжилгээний газрын даргын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

2. Сэвжидийн Энхтүвшинг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Цаг уур, орчны шинжилгээний газрын даргаар томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД М.ЭНХБОЛД**

**БАЙГАЛЬ ОРЧНЫ САЙД И.ЭРДЭНЭБААТАР**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2006 оны 4 дүгээр сарын 5-ны өдөр | Дугаар 68 | Улаанбаатар хот

**Ажлаас чөлөөлөх, ажилд томилох тухай**

Тагнуулын байгууллагын тухай хуулийн 15.2-ыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Доржготовын Чимэд-Юндэнг Засгийн газрын тохируулагч агентлаг-Тагнуулын ерөнхий газрын дэд даргын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

2. Самдангийн Жаргалсайханыг Засгийн газрын тохируулагч агентлаг-Тагнуулын ерөнхий газрын дэд даргаар томилсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА С.БАТБОЛД

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2006 оны 4 дүгээр сарын 5-ны өдөр | Дугаар 69 | Улаанбаатар хот

**Хэлэлцээр батлах тухай**

Олон улсын гэрээний тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

2003 оны 7 дугаар сарын 1-ний өдөр Москва хотноо гарын үсэг зурсан "Боловсролын баримт бичиг, эрдмийн зэрэг, эрдмийн цолыг харилцан хүлээн зөвшөөрөх тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын Хэлэлцээр"-ийг баталсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД М.ЭНХБОЛД

БАЙГАЛЬ ОРЧНЫ САЙД БӨГӨӨД БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙДЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ И.ЭРДЭНЭБААТАР

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2006 оны 4 дүгээр сарын 5-ны өдөр | Дугаар 70 | Улаанбаатар хот

**Хамгаалалтын бүс тогтоох тухай**

Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 6 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Булган аймгийн Дашинчилэн сумын нутагт орших улсын хамгаалалтад байгаа Цогт тайжийн цагаан байшингийн балгас, Бичигт хөшөө болон Хар Бухын балгасын хамгаалалтын бүсийг хавсралт ёсоор тогтоосугай.

2. Түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйлийн хадгалалт, хамгаалалт, бүрэн бүтэн байдалд хохирол учруулахуйц үйл ажиллагаа явуулах, хамгаалалтын бүсэд барилга барихыг хориглох, дурсгалуудын хамгаалалтын бүсийн шон, тэмдэг тавих, шаардлагатай газруудад хашаа барьж хамгаалах талаар дэс дараатай арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Булган аймгийн Засаг дарга М.Оюунбатад үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД М.ЭНХБОЛД

БАЙГАЛЬ ОРЧНЫ САЙД БӨГӨӨД БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙДЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ И.ЭРДЭНЭБААТАР

*Засгийн газрын 2006 оны 70 дугаар тогтоолын хавсралт*

### ХАМГААЛАЛТЫН БҮСИЙН ХИЛИЙН ЦЭГҮҮД
(Солбицлын жагсаалт)

| Цэгийн дугаар | Байршил | Геодезийн солбицол | | Талбай (га) |
|---|---|---|---|---|
| | | B | L | |
| 1 | Булган аймгийн Дашинчилэн сум. Цогт тайжийн цагаан байшингийн балгас, Бичигт хөшөө | 48-01-30 | 104-21-55 | 920 га |
| 2 | Булган аймгийн Дашинчилэн сум. Цогт тайжийн цагаан байшингийн балгас, Бичигт хөшөө | 48-01-30 | 104-19-30 | |
| 3 | Булган аймгийн Дашинчилэн сум. Цогт тайжийн цагаан байшингийн балгас, Бичигт хөшөө | 48-00-15 | 104-19-30 | |
| 4 | Булган аймгийн Дашинчилэн сум. Цогт тайжийн цагаан байшингийн балгас, Бичигт хөшөө | 48-00-15 | 104-22-50 | |
| 1 | Булган аймгийн Дашинчилэн сум. Хар Бухын балгас | 47-52-00 | 103-52-30 | 1080 га |
| 2 | Булган аймгийн Дашинчилэн сум. Хар Бухын балгас | 47-54-00 | 103-52-30 | |
| 3 | Булган аймгийн Дашинчилэн сум. Хар Бухын балгас | 47-54-00 | 103-55-30 | |
| 4 | Булган аймгийн Дашинчилэн сум. Хар Бухын балгас | 47-52-00 | 103-54-00 | |

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

**2006 оны 4 дүгээр сарын 5-ны өдөр** **Дугаар 71** **Улаанбаатар хот**

**Байгалийн бүсчлэлд хамрагдах сумдын нэрийн жагсаалт батлах тухай**

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 26 дугаар зүйлийн 7 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын байгалийн бүсчлэлд хамрагдах сумдын нэрийн жагсаалтыг хавсралт ёсоор батлсугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Норматив тогтоох тухай" Засгийн газрын 1997 оны 2 дугаар сарын 12-ны өдрийн 41 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Байгаль хамгаалагчийн хариуцан ажиллах талбайн норматив"-ын "1. Дархан цаазат болон байгалийн цогцолборт газар" гэснээс бусад заалт, хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД М.ЭНХБОЛД**

**БАЙГАЛЬ ОРЧНЫ САЙД И.ЭРДЭНЭБААТАР**

*Засгийн газрын 2006 оны 71 дүгээр тогтоолын хавсралт*

### БАЙГАЛИЙН БҮСЧЛЭЛД ХАМРАГДАХ СУМДЫН НЭРИЙН ЖАГСААЛТ

| Байгалийн бүс | Аймгийн нэр | | Сумын нэр |
|---|---|---|---|
| Өндөр уулын бүс | Баян-Өлгий аймаг | 1 | Алтай |
| | | 2 | Алтанцөгц |
| | | 3 | Баяннуур |
| | | 4 | Бугат |
| | | 5 | Булган |
| | | 6 | Буянт |
| | | 7 | Дэлүүн |
| | | 8 | Ногооннуур |
| | | 9 | Сагсай |
| | | 10 | Толбо |
| | | 11 | Улаанхус |
| | | 12 | Цэнгэл |

| | | | |
|---|---|---|---|
| | Увс аймаг | 1 | Бөхмөрөн |
| | | 2 | Давст |
| | | 3 | Малчин |
| | | 4 | Наранбулаг |
| | | 5 | Өмнөговь |
| | | 6 | Сагил |
| | | 7 | Тариалан |
| | | 8 | Түргэн |
| | | 9 | Ховд |
| | Ховд аймаг | 1 | Дуут |
| | | 2 | Зэрэг |
| | | 3 | Мянгад |
| | | 4 | Мөст |
| | | 5 | Мөнххайрхан |
| | | 6 | Ховд |
| | | 7 | Цэцэг |
| | | 8 | Эрдэнэбүрэн |
| | Говь-Алтай аймаг | 1 | Баян-Уул |
| | | 2 | Есөнбулаг |
| | | 3 | Жаргалан |
| | | 4 | Тайшир |
| | | 5 | Тонхил |
| | Баянхонгор аймаг | 1 | Баян-Овоо |
| | | 2 | Заг |
| | | 3 | Баянбулаг |
| | | 4 | Гурванбулаг |
| | | 5 | Богд |
| | | 6 | Бууцагаан |
| | | 7 | Баянхонгор |
| | Өмнөговь аймаг | 1 | Даланзадгад |
| | | 2 | Сэврэй |
| | Өвөрхангай аймаг | 1 | Нарийнтээл |
| | | 2 | Хайрхандулаан |
| | Завхан аймаг | 1 | Завханмандал |
| | | 2 | Сантмаргац |
| | | 3 | Эрдэнэхайрхан |
| Ойт хээрийн бүс | Увс аймаг | 1 | Өндөрхангай |
| | | 2 | Хяргас |
| | | 3 | Цагаанхайрхан |
| | | 4 | Зүүнхангай |
| | Баянхонгор аймаг | 1 | Галуут |
| | | 2 | Эрдэнэцогт |
| | | 3 | Жаргалант |
| | Өвөрхангай аймаг | 1 | Хужирт |
| | | 2 | Хархорин |
| | | 3 | Бат-Өлзий |
| | | 4 | Зүүнбаян-Улаан |
| | | 5 | Уянга |
| | Завхан аймаг | 1 | Алдархаан |
| | | 2 | Баянтэс |
| | | 3 | Баянхайрхан |
| | | 4 | Булнай |
| | | 5 | Идэр |
| | | 6 | Их-Уул |
| | | 7 | Нөмрөг |
| | | 8 | Отгон |
| | | 9 | Сонгино |
| | | 10 | Түдэвтэй |
| | | 11 | Тэлмэн |
| | | 12 | Цагаанхайрхан |
| | | 13 | Цагаанчулуут |
| | | 14 | Цэцэн-Уул |
| | | 15 | Шилүүстэй |
| | | 16 | Яруу |
| | | 17 | Асгат |
| | | 18 | Тэс |
| | | 19 | Улиастай |
| | Хөвсгөл аймаг | 1 | Алаг-Эрдэнэ |
| | | 2 | Арбулаг |
| | | 3 | Баянзүрх |
| | | 4 | Бүрэнтогтох |
| | | 5 | Галт |
| | | 6 | Жаргалант |
| | | 7 | Мөрөн |
| | | 8 | Их-Уул |
| | | 9 | Рашаант |
| | | 10 | Рэнчинлхүмбэ |
| | | 11 | Тариалан |
| | | 12 | Тосонцэнгэл |
| | | 13 | Төмөрбулаг |
| | | 14 | Түнэл |

| | | | |
|---|---|---|---|
| | | 15 | Улаан-Уул |
| | | 16 | Ханх |
| | | 17 | Цагааннуур |
| | | 18 | Цагаан-Уул |
| | | 19 | Цагаан-Үүр |
| | | 20 | Цэцэрлэг |
| | | 21 | Чандмань-Өндөр |
| | | 22 | Шинэ-Идэр |
| | | 23 | Эрдэнэбулган |
| | Булган аймаг | 1 | Баян-Агт |
| | | 2 | Бугат |
| | | 3 | Булган |
| | | 4 | Бурэгхангай |
| | | 5 | Могод |
| | | 6 | Орхон |
| | | 7 | Сайхан |
| | | 8 | Сэлэнгэ |
| | | 9 | Тэшиг |
| | | 10 | Хангал |
| | | 11 | Хишиг-Өндөр |
| | | 12 | Хутаг-Өндөр |
| | Архангай аймаг | 1 | Ихтамир |
| | | 2 | Чулуут |
| | | 3 | Хангай |
| | | 4 | Тариат |
| | | 5 | Цахир |
| | | 6 | Өндөр-Улаан |
| | | 7 | Эрдэнэмандал |
| | | 8 | Жаргалант |
| | | 9 | Цэцэрлэг |
| | | 10 | Хайрхан |
| | | 11 | Батцэнгэл |
| | | 12 | Өлзийт |
| | | 13 | Хотонт |
| | | 14 | Цэнхэр |
| | | 15 | Тувшруулэх |
| | | 16 | Булган |
| | | 17 | Эрдэнэбулган |
| | Орхон аймаг | 1 | Баян-Өндөр |
| | | 2 | Жаргалант |
| | Сэлэнгэ аймаг | 1 | Алтанбулаг |
| | | 2 | Баруунбүрэн |
| | | 3 | Баянгол |
| | | 4 | Ерөө |
| | | 5 | Жавхлант |
| | | 6 | Зүүнбүрэн |
| | | 7 | Мандал |
| | | 8 | Орхон |
| | | 9 | Орхонтуул |
| | | 10 | Сайхан |
| | | 11 | Сант |
| | | 12 | Сүхбаатар |
| | | 13 | Түшиг |
| | | 14 | Хушаат |
| | | 15 | Хүдэр |
| | | 16 | Цагааннуур |
| | | 17 | Шаамар |
| | Дархан-Уул аймаг | 1 | Дархан |
| | | 2 | Хонгор |
| | | 3 | Орхон |
| | | 4 | Шарынгол |
| | Төв аймаг | 1 | Алтанбулаг |
| | | 2 | Батсүмбэр |
| | | 3 | Баяндэлгэр |
| | | 4 | Цээл |
| | | 5 | Угтаал |
| | | 6 | Баянцогт |
| | | 7 | Баянчандмань |
| | | 8 | Борнуур |
| | | 9 | Жаргалант |
| | | 10 | Заамар |
| | | 11 | Мөнгөнморьт |
| | | 12 | Сүмбэр |
| | | 13 | Эрдэнэ |
| | | 14 | Зуунмод |
| | Улаанбаатар хот | 1 | Баянгол |
| | | 2 | Баянзүрх |
| | | 3 | Сонгинохайрхан |
| | | 4 | Сүхбаатар |
| | | 5 | Хан-Уул |
| | | 6 | Чингэлтэй |

| | | | |
|---|---|---|---|
| | | 7 | Багануур |
| | | 8 | Багахангай |
| | | 9 | Налайх |
| | Дорнод аймаг | 1 | Баяндун |
| | | 2 | Баян-Уул |
| | Хэнтий аймаг | 1 | Батноров |
| | | 2 | Батширээт |
| | | 3 | Баян-Адрага |
| | | 4 | Биндэр |
| | | 5 | Дадал |
| | | 6 | Жаргалтхаан |
| | | 7 | Норовлин |
| | | 8 | Өмнөдэлгэр |
| | | 9 | Цэнхэрмандал |
| Тал хээрийн бүс | Архангай | 1 | Өгийнуур |
| | | 2 | Хашаат |
| | Баянхонгор | 1 | Бөмбөгөр |
| | | 2 | Хүрээмарал |
| | Булган | 1 | Баяннуур |
| | | 2 | Рашаант |
| | | 3 | Дашинчилэн |
| | | 4 | Гурванбулаг |
| | Өвөрхангай аймаг | 1 | Баян-Өндөр |
| | | 2 | Тарагт |
| | | 3 | Өлзийт |
| | | 4 | Арвайхээр |
| | | 5 | Сант |
| | | 6 | Бүрд |
| | | 7 | Есөнзүйл |
| | Дорнод аймаг | 1 | Баянтүмэн |
| | | 2 | Булган |
| | | 3 | Гурванзагал |
| | | 4 | Дашбалбар |
| | | 5 | Матад |
| | | 6 | Холонбуйр |
| | | 7 | Хэрлэн |
| | | 8 | Халхгол |
| | | 9 | Сэргэлэн |
| | | 10 | Цагаан-Овоо |
| | | 11 | Чойбалсан |
| | | 12 | Чулуунхороот |
| | Хэнтий аймаг | 1 | Дэлгэрхаан |
| | | 2 | Баянхутаг |
| | | 3 | Мөрөн |
| | | 4 | Баян-Овоо |
| | | 5 | Баянмөнх |
| | | 6 | Хэрлэн |
| | Дундговь аймаг | 1 | Дэлгэрцогт |
| | | 2 | Дэрэн |
| | | 3 | Говь-Угтаал |
| | | 4 | Цагаандэлгэр |
| | | 5 | Эрдэнэдалай |
| | | 6 | Адаацаг |
| | | 7 | Луус |
| | | 8 | Сайхан-Овоо |
| | | 9 | Сайнцагаан |
| | Сүхбаатар аймаг | 1 | Асгат |
| | | 2 | Баруун-Урт |
| | | 3 | Дарьганга |
| | | 4 | Мөнххаан |
| | | 5 | Түвшинширээ |
| | | 6 | Түмэнцогт |
| | | 7 | Сүхбаатар |
| | | 8 | Халзан |
| | | 9 | Уулбаян |
| | | 10 | Эрдэнэцагаан |
| | Төв | 1 | Баянхангай |
| | | 2 | Лүн |
| | | 3 | Аргалант |
| | | 4 | Баянжаргалант |
| | | 5 | Дэлгэрхаан |
| | | 6 | Эрдэнэсант |
| | | 7 | Архуст |
| | | 8 | Бүрэн |
| | | 9 | Өндөрширээт |
| | | 10 | Сэргэлэн |
| | | 11 | Баян |
| | | 12 | Баян-Өнжүүл |
| | | 13 | Баянцагаан |
| | Увс аймаг | 1 | Өлгий |
| | | 2 | Улаангом |

| | | | |
|---|---|---|---|
| | Ховд аймаг | 1 | Буянт |
| | | 2 | Жаргалант |
| | Говь-Алтай аймаг | 1 | Дэлгэр |
| | Говьсүмбэр аймаг | 1 | Шивээговь |
| | | 2 | Баянтал |
| | | 3 | Сүмбэр |
| | Дорноговь | 1 | Айраг |
| | | 2 | Алтанширээ |
| | | 3 | Даланжаргалан |
| | | 4 | Дэлгэрэх |
| | | 5 | Иххэт |
| Цөлөрхөг хээрийн бүс | Завхан | 1 | Дөрвөлжин |
| | | 2 | Ургамал |
| | Говь-Алтай | 1 | Цээл |
| | | 2 | Төгрөг |
| | | 3 | Шарга |
| | | 4 | Халиун |
| | | 5 | Бигэр |
| | | 6 | Чандмань |
| | | 7 | Дарви |
| | Дундговь | 1 | Баянжаргалан |
| | | 2 | Өндөршил |
| | | 3 | Гурвансайхан |
| | | 4 | Өлзийт |
| | | 5 | Хулд |
| | | 6 | Дэлгэрхангай |
| | Өмнөговь | 1 | Булган |
| | | 2 | Манлай |
| | | 3 | Мандал-Овоо |
| | | 4 | Цогт-Овоо |
| | | 5 | Баяндалай |
| | | 6 | Цогтцэций |
| | | 7 | Ханхонгор |
| | Дорноговь | 1 | Өргөн |
| | | 2 | Улаанбадрах |
| | | 3 | Эрдэнэ |
| | | 4 | Замын-Үүд |
| | | 5 | Хатанбулаг |
| | | 6 | Сайншанд |
| | | 7 | Сайхандулаан |
| | | 8 | Хөвсгөл |
| | Увс аймаг | 1 | Баруунтуруун |
| | | 2 | Зүүнговь |
| | | 3 | Тэс |
| | | 4 | Завхан |
| | Баянхонгор аймаг | 1 | Өлзийт |
| | | 2 | Жинст |
| | Өвөрхангай аймаг | 1 | Баянгол |
| | | 2 | Төгрөг |
| | | 3 | Богд |
| | | 4 | Баруунбаян-Улаан |
| | | 5 | Гучин-Ус |
| | Сүхбаатар аймаг | 1 | Баяндэлгэр |
| | | 2 | Наран |
| | | 3 | Онгон |
| | Хэнтий | 1 | Галшар |
| | | 2 | Дархан |
| | Ховд | 1 | Дарви |
| | | 2 | Чандмань |
| | | 3 | Манхан |
| | | 4 | Дөргөн |
| Цөлийн бүс | Говь-Алтай аймаг | 1 | Цогт |
| | | 2 | Алтай |
| | | 3 | Бугат |
| | | 4 | Эрдэнэ |
| | | 5 | Хөхморьт |
| | Өмнөговь аймаг | 1 | Гурвантэс |
| | | 2 | Номгон |
| | | 3 | Ноён |
| | | 4 | Ханбогд |
| | | 5 | Хүрмэн |
| | | 6 | Баян-Овоо |
| | Ховд аймаг | 1 | Алтай |
| | | 2 | Булган |
| | | 3 | Үенч |
| | Баянхонгор аймаг | 1 | Шинэжинст |
| | | 2 | Баянлиг |
| | | 3 | Баянговь |
| | | 4 | Баянцагаан |
| | | 5 | Баян-Өндөр |
| | | 6 | Баацагаан |
| | Дорноговь | 1 | Мандах |
| Бүгд | 22 | | 328 сум, 9 дүүрэг |

Засгийн газрын 2006 оны 57 дугаар тогтоолын хавсралт

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ*

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | 3. Бие даан амьдрах чадваргүй, зайлшгүй асран хамгаалагч [illegible] хөгжлийн [illegible] байгаа хүмүүст мөнгөн тэтгэмж олгох амьдрал ахуйг нь тусална. | [illegible] | Л.Одончимэд |
| | | | 4. Олон хүүхэд төрүүлж, өсгөж бойжуулсан алдарт эхийн одонтой ахмад эхчүүдэд жилд нэг удаа мөнгөн тусламж үзүүлнэ. | 2006 оноос | Л.Одончимэд |
| 119 | 2.6.9 | Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ, нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, төрийн албан хаагчдын болон төсөвт байгууллагад ажиллагчдын үндсэн цалингийн хэмжээг эдийн засгийн өсөлт, инфляцийн түвшин, төсөвт байгууллагын зардлын хэмнэлттэй уялдуулан нэмэгдүүлэх бодлого баримтална. | 1. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ, нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн хэмжээ, төрийн албан хаагчид болон төсөвт байгууллагад ажиллагчдын үндсэн цалингийн хэмжээг эдийн засгийн өсөлт, инфляцийн түвшинтэй уялдуулан индексжүүлэн нэмэгдүүлнэ. | Жил бүр | Л.Одончимэд<br>Н.Баяртсайхан |
| 120 | 2.6.10 | Нийгмийн хамгааллын үйлчилгээг нийгэм, хамт олонд түшиглэсэн хэлбэрээр хөнгөн шуурхай, уян хатан хүргэх үүрэг бүхий нийгмийн үйлчилгээний төвийг бүсийн төвүүд болон нийслэлийн зарим дүүрэгт туршин ажиллуулна. | 1. АХБ-ны техник туслалцааны дэмжлэгтэйгээр Өвөрхангай аймгийн Арвайхээр хот болон нийслэлийн Баянгол дүүрэгт нийгмийн үйлчилгээний загвар төвийг туршин ажиллуулна. | 2005 оноос | Л.Одончимэд |
| | | | 2. Нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг нэг цэгээс иргэдэд хүргэх нийгмийн үйлчилгээний төвийг бүсийн төвүүдэд байгуулж ажиллуулна. | 2006-2008 | Л.Одончимэд<br>Н.Баяртсайхан |
| | | | 3. Төвөөс алслагдсан айл өрх, иргэд, хүүхдэд "Нийгмийн суурь" үйлчилгээг цогцоор хүргэх тусгай хөтөлбөр хэрэгжүүлэх ажлыг олон улсын болон гадаадын түнш байгууллагуудтай хамтран зохион байгуулна. | 2005-2008 | Л.Одончимэд<br>Н.Баяртсайхан |
| | | | 4. Нийгмийн халамжийн тогтолцоонд өөрчлөлт хийх асуудлыг судлан шийдвэрлэж, нийгэм, хамт олонд түшиглэсэн халамж, үйлчилгээний шинэ хэлбэрийг турших замаар нийгмийн халамжид хамрагдах шалгуур үзүүлэлт, өрх, иргэдийн амьжиргааг тодорхойлох аргачлалыг боловсронгуй болгоно. | 2005 | Л.Одончимэд |
| 121 | 2.6.11 | Ажилтнуудын мэргэжлийн ур чадварыг харилцан зөвшөөрөх, магадлан итгэмжлэх, үнэмлэхжүүлэх болон ажиллах хүчний шилжилт хөдөлгөөн, хөдөлмөрлөх эрхийг харилцан зөвшөөрөх гэрээ, хэлэлцээрийг сонирхсон орнуудтай байгуулж хэрэгжүүлнэ. | 1. Ази-Номхон далайн орнуудын магадлан итгэмжлэх батламжлах комисст гишүүнээр элсч, ажилчдын мэргэжлийн ур чадварыг харилцан хүлээн зөвшөөрөх, ажиллах хүчний шилжих хөдөлгөөн, хөдөлмөрлөх эрхийг харилцан зөвшөөрөх асуудлаар Азид идэвхтэй үйл ажиллагаа явуулна. | 2004-2008 | Л.Одончимэд<br>Ө.Энхтүвшин<br>Н.Энхболд |
| | | | 2. Ажиллах хүчний гадаад шилжилт хөдөлгөөн, хөдөлмөрлөх эрхийг харилцан зөвшөөрөх сонирхол бүхий орнуудын саналыг нарийвчлан судалсны үндсэн дээр гэрээ, хэлэлцээр байгуулна. | 2005 оноос | Л.Одончимэд<br>Н.Энхболд |
| 122 | 2.6.12 | Эдийн засгийн тогтвортой байдлыг макро түвшинд хангаж, өсөлтийг дэмжих, бизнесийн таатай орчин бүрдүүлэх, дэд бүтцийг хөгжүүлэхэд хөрөнгө оруулах замаар 145 мянгаас доошгүй ажлын байр шинээр бий болгоно. | 1. Эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, өсөлтийг дэмжих, гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татах, бизнесийн таатай орчинг бүрдүүлэх, дэд бүтцийг хөгжүүлэх бодлогыг ОУВС, ДБ зэрэг олон улсын банк санхүүгийн түнш байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ. | Жил бүр | Л.Одончимэд |
| | | | 2. Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалтай уялдуулан дэд бүтцийн салбар, стратегийн ач холбогдолтой бүс нутаг, үйлдвэрлэлд чиглэсэн хувийн хөрөнгө оруулалтыг дэмжих зээл, санхүү, татварын урамшуулал бий болгох, хамтарсан хөрөнгө оруулах асуудлыг судлан боловсруулж, холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах арга хэмжээ авна. | Жил бүр | Л.Одончимэд |
| | | | 3. Аж ахуйн нэгж, байгууллагын ажлын байрны талаарх мэдээлэл, судалгааг сайжруулна. | 2006 оноос | Л.Одончимэд |
| | | | 4. Эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татах, бизнесийн таатай орчинг бүрдүүлэх, дэд бүтцийг хөгжүүлэх замаар жил бүр 37000-аас доошгүй ажлын байр бий болгоход Засгийн газрын зүгээс дэмжлэг үзүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ. | Жил бүр | Л.Одончимэд<br>Сайд нар |

(*Үргэлжлэл. Түрүүч нь "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 17 дугаарт нийтлэгдсэн.)

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | 5. Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг сайжруулж жилд 25000-аас доошгүй хүнийг ажилд зуучилна. | Жил бүр | Л.Одончимэд |
| | | | 6. Ховор мэргэжлийн ажилчид бэлтгэх, ажилчдын мэргэжлийн ур чадварыг сайжруулах үндсэн дээр гадаадын хөрөнгө оруулалттай үйлдвэрт ажиллаж байгаа монгол ажилчдын тоог нэмэгдүүлэх арга хэмжээ авна. | 2005-2008 | Л.Одончимэд |
| | | | 7. "Дөчин мянган орон сууц хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх замаар ажлын байрыг шинээр бий болгоно. | 2005-2008 | Ж.Наранцацралт<br>Л.Одончимэд |
| | | | 8. Жижиг, дунд үйлдвэр, жижиг бизнесийг өргөтгөх, санхүү, зээлийн механизм бий болгох замаар үйлдвэр, худалдаа, уул уурхайн салбарт ажлын байр нэмэгдүүлэх санхүү, зээлийн бодлогыг боловсронгуй болгох санал боловсруулж хэрэгжүүлэх арга хэмжээ авна. | 2005-2008 | Б.Жаргалсайхан |
| 123 | 2.6.13 | Ажиллах хүчний бүтээмж, зах зээлд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд онцгой анхаарна. | 1. Нийгмийн хамгааллын салбарын хөгжлийн хөтөлбөр, төслийн хүрээнд эхэлсэн мэргэжлийн болон аж ахуй эрхлэх ур чадварын сургалтын тогтолцоог бүрдүүлэх асуудлыг шийдвэрлэж, мэргэжлийн боловсрол сургалтын 6 бүсийн төв, хөдөлмөр эрхлэлт сургалтын 25, хөдөлмөр эрхлэлт боловсролын 40 төв байгуулж, эрэлтэд тулгуурласан "Эрхийн бичиг"-ийн сургалтын системийг өргөжүүлэн жилд 12000-аас доошгүй хүнийг мэргэжлийн болон ур чадварын сургалтад хамруулна. | 2005-2008 | Л.Одончимэд |
| | | | 2. Ажилтны мэргэжлийн ур чадварыг хөдөлмөрийн зах зээлийн шаардлагад нийцүүлэн хөгжүүлэхэд чиглэгдсэн мэргэжлийн ур чадварын шалгалт зохион байгуулах, мэргэжлийн гэрчилгээ олгох тогтолцоо бүрдүүлнэ. | 2005-2008 | Л.Одончимэд |
| | | | 3. Ажилчдын бүтээмж нэмэгдүүлэх хөдөлгөөн, ажил дээрх сургалт зохион байгуулах арга зүйг боловсруулж, сонгосон аж ахуйн нэгж байгууллагад нэвтрүүлнэ. | 2004-2008 | Л.Одончимэд |
| | | | 4. Эрэлтэд тулгуурласан "Эрхийн бичиг"-ийн сургалтын системийг өргөжүүлж төвлөрсөн хот, орон нутагт нэвтрүүлнэ. | 2005 оноос | Л.Одончимэд |
| | | | 5. Фермерийн болон аж ахуй эрхлэх ур чадварын сургалтыг өргөжүүлнэ. | 2006 оноос | Л.Одончимэд |
| | | | 6. ХЭДС-д төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлж жил бүр төсвийн орлогын 0,3 хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг хуваарилдаг болно. | 2006 оноос | Л.Одончимэд |
| 124 | 2.6.14 | Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн дэргэдэх хөдөлмөрийн бирж, мэдээллийн төвүүдийг багтаан орчин үеийн мэдээлэл, харилцааны технологи бүхий мэдээллийн сүлжээ байгуулна. | 1. Ажил зуучлал, хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн үйлчилгээ явуулж байгаа төрийн бус байгууллагууд, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг дэмжин, мэдээлэл солилцоог сайжруулах, тэднийг хамруулсан мэдээллийн сүлжээ, вэб хуудастай болох асуудлыг үе шаттайгаар шийдвэрлүүлнэ. | 2005-2008 | Л.Одончимэд<br>С.Батболд |
| 125 | 2.6.15 | Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг гаргах эрх зүйн зохицуулалтыг бий болгоно. | 1. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын тухай хуульд ажил олгогч болон ажилчдад зориулсан сургалт сурталчилгаа, мэдээлэл зэрэг урьдчилан сэргийлэх арга хэмжээнд уг сангаас хөрөнгө зарцуулах талаар нэмэлт, өөрчлөлт оруулж УИХ-д өргөн мэдүүлнэ. | 2005 | Л.Одончимэд<br>Д.Одбаяр |
| 126 | 2.6.16 | Аж ахуйн нэгж, байгууллагад хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн менежментийг нэвтрүүлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг ажил олгогчид болон ажиллагчдын идэвхтэй оролцоотойгоор хэрэгжүүлнэ. | 1. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн менежментийн систем нэвтрүүлэх мастер төлөвлөгөө боловсруулна. | 2005 | Л.Одончимэд |
| | | | 2. Аж ахуйн нэгж, байгууллагад хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн менежментийн систем нэвтрүүлэх удирдамж, түүний загвар боловсруулан сонгосон аж ахуйн нэгж, байгууллагад нэвтрүүлэх, турших арга хэмжээг холбогдох байгууллагатай хамтран [illegible] хэрэгжүүлнэ. | 2006 [illegible] | Л.Одон[illegible] |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 127 | 2.6.17 | Гадаадад хөдөлмөр эрхлэгчдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах, нийгмийн хамгааллыг сайжруулах зорилгоор холбогдох хууль тогтоомжийг боловсронгуй болгоно. Тэдэнд төрөөс үзүүлэх үйлчилгээний хүртээмж, чанарыг дээшлүүлж, зуучлах үйлчилгээнд төрийн байгууллагуудын оролцоог нэмэгдүүлнэ. | 1. Гадаад хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг чиг хандлага, олон улсын гэрээ хэлэлцээрт нийцүүлэн гадаадад ажиллах хүч гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах эрх зүйн орчинг боловсронгуй болгоно.<br>2. Гадаад хөдөлмөр эрхлэлтийн менежментийн чадавхийг сайжруулах асуудлаар Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагатай идэвхтэй хамтран ажиллаж техникийн туслалцаа авна. | 2005<br>2004-2008 | Л.Одончимэд<br>Н.Энхболд<br>Л.Одончимэд<br>Н.Энхболд |
| 128 | 2.6.18 | Ажиллагсдад эрхээ хамгаалуулахад дэмжлэг үзүүлж, хөдөлмөрийнхөө үр шимийг шударга хүртэх боломжийг нэмэгдүүлнэ. Үйлдвэрчний эвлэлийн болон ажил олгогч эздийн байгууллагатай хамтран нийгмийн түншлэлийн харилцааг хөгжүүлнэ. | 1. Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагаас дэвшүүлэн тавьсан "Зохистой хөдөлмөрийн төлөө" үйл ажиллагааны Үндэсний төлөвлөгөөг Засгийн газар, ажил олгогчид болон хөдөлмөрчдийн төлөөллийн байгууллагууд хамтран хэрэгжүүлнэ.<br>2. Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагатай хамтран "Нийгмийн түншлэлийг дэмжих" төслийн хүрээнд нийгмийн түншлэлийн харилцааг орон нутагт хөгжүүлэх арга хэмжээг үе шаттайгаар авна.<br>3. Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт хэлэлцээрүүдийг байгуулж хэрэгжүүлнэ. | 2005<br>2005-2008<br>2005-2008 | Л.Одончимэд<br>Л.Одончимэд<br>Л.Одончимэд |
| 129 | 2.6.19 | Албадлагын хөдөлмөрийг устгах тухай олон улсын хөдөлмөрийн байгууллагын холбогдох конвенцид нэгдэн орж, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлнэ. | 1. Албадлагын хөдөлмөрийн тухай Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын 29, Албадлагын хөдөлмөрийг устгах тухай Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын 105 дугаар конвенцид нэгдэн орох асуудлыг шийдвэрлүүлнэ.<br>2. Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг ялган тогтоож, улмаар арилгах талаар дэд хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ. | 2005<br>2006 | Л.Одончимэд<br>Н.Энхболд<br>М.Энхсайхан |
| 130 | 2.6.20 | Эдийн засгийн хөгжлийн тэргүүлэх чиглэл, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээтэй уялдуулан аж ахуйн нэгжийн оролцоотой үндэсний мэргэжилтэн, мэргэжилтэй ажилчид бэлтгэх ажлыг хэтийн төлөв гарган хэрэгжүүлнэ. | 1. Нийгмийн хамгааллын салбарын хөгжлийн хөтөлбөр, төслийн хүрээнд эхэлсэн Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн судалгаар тогтмолжуулж, энэ талаар олон нийтэд мэдээлэх ажлыг өргөжүүлнэ.<br>2. Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн тоон болон чанарын судалгаанд үндэслэн үндэсний мэргэжилтэн, мэргэжилтэй ажилчдын хэрэгцээний хэтийн төлөвийг тооцно.<br>3. Барилгын салбарын мэргэжилтэн, мэргэжилтэй ажилчид бэлтгэх тусгай хөтөлбөрийг холбогдох яамдтай хамтран боловсруулж хэрэгжүүлнэ. | 2004 оноос<br>2006 оноос<br>2005-2008 | Л.Одончимэд<br>Л.Одончимэд<br>Ө.Энхтүвшин<br>Ж.Наранцацралт<br>Ө.Энхтүвшин<br>Л.Одончимэд |
| 131 | 2.6.21 | Албан бус хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах төрийн бодлогыг боловсруулж, хэрэгжүүлнэ. | 1. Албан бус хөдөлмөр эрхлэлтийн талаар төрөөс баримтлах бодлогыг батлуулж хэрэгжүүлнэ. | 2005 | Л.Одончимэд |
| 132 | 2.6.22 | Хоршоо, нөхөрлөл байгуулах, хамтын хөдөлмөр, аж ахуй эрхлэх ур чадварын сургалт явуулах, зээл, тусламж зэрэг хөрөнгийн эх үүсвэрээр дэмжих замаар иргэдийг ажлын байраар хангах болон орхийн орлогыг нэмэгдүүлэхэд тусална. | 1. Аж ахуйн нэгжийн ээлжит тооллогыг явуулж, аж ахуйн нэгжийн регисрийн мэдээллийн санг баяжуулна.<br>2. 2005 оныг бичил зээлийн жил болгоно. Бичил зээлийн жилийн хүрээнд хөдөөгийн иргэд, ядуу хүмүүст зориулсан бичил зээл, санхүүгийн туршилтын төслийг НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөртэй хамтран хэрэгжүүлнэ.<br>3. Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын "Бизнесээ эхэл, бизнесээ хөгжүүл" сургалтын хөтөлбөрийг ашиглан малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд аж ахуй эрхлэх сургалтыг зохион байгуулна.<br>4. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулинд өөрчлөлт оруулах замаар Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгох жижиг зээлийг ажлын байр, орлого нэмэгдүүлэх зорилгод түлхүү хандуулна. | 2005-2008<br>2005<br>2005 оноос<br>2005 оноос | П.Бямбацэрэн<br>Н.Баяртсайхан<br>Л.Одончимэд<br>Д.Тэрбишдагва<br>Л.Одончимэд<br>Д.Тэрбишдагва<br>Л.Одончимэд |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | 5. Жижиг бизнес эрхлэгчид, бичил аж ахуйн нэгжийг дэмжин хөгжүүлэх үйлчилгээ бүхий бизнес инкубаторыг байгуулж, зээлжээ өгөх үйлчилгээг хөгжүүлэх арга хэмжээ авч, үйл ажиллагааг нь хэвшүүлнэ. | 2005 оноос | Б.Жаргалсайхан<br>Л.Одончимэд<br>Ө.Энхтүвшин<br>Д.Тэрбишдагва |
| | | | 6. Малчдын бүлэг, хоршоо, нөхөрлөл зэрэг хамтран ажиллаж байгаа албан бус хэлбэрүүдийг дэмжинэ. | 2005-2008 | Д.Тэрбишдагва |
| | | | 7. Хоршоодод дэмжлэг үзүүлэхэд чиглэгдсэн гадаадын зээл, тусламж, төсөл хөтөлбөрүүдийн уялдааг сайжруулахад дэмжлэг үзүүлнэ. | 2005-2008 | Д.Тэрбишдагва |
| | | | 8. Хоршооны аудитын эрх зүйн орчныг бүрдүүлнэ. | 2005-2008 | Д.Тэрбишдагва |

## Гурав. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

**Эдийн засаг, санхүүгийн салбар дахь тогтворжилтыг бататган хувийн хэвшил, технологийн шинэчлэлд тулгуурласан бүтцийн өөрчлөлтийг гүнзгийрүүлж экспорт, гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэн эдийн засгийн өсөлтийг хангана.**

**Эдийн засгийн өсөлтийн хурдцыг жилд 6 хувиас доошгүй байлгах зорилгоор дараах бодлогыг хэрэгжүүлнэ:**

- **Макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангана.**
- **Банк, санхүүгийн салбарыг бэхжүүлнэ.**
- **Хувьчлалыг үргэлжлүүлж, газар болон хөрөнгийн эдийн засгийн үр нөлөөг нэмэгдүүлнэ.**
- **Үйлдвэрлэл, хөдөө аж ахуй, үйлчилгээний салбарыг дэмжиж, экспортыг нэмэгдүүлнэ.**
- **Хөрөнгө оруулалтыг хамгаалсан найдвартай орчинг бий болгоно.**
- **Эдийн засгийн өсөлтөд нөлөөлөхүйц дэд бүтцийг эрчимтэй хөгжүүлнэ.**
- **Эдийн засгийн өсөлтийг хангахад чиглэсэн шинэ чадавхийг бий болгоно.**
- **Гадаад худалдааны идэвхтэй бодлогоор эдийн засгийн өсөлтийг дэмжинэ.**

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **3.1. Макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах хүрээнд:** | | | | | |
| 133 | 3.1.1 | Инфляцийн түвшинг нэг оронтой тоонд байлгана. | 1. Инфляцийн түвшинг нэг оронтой тоонд байлгах үүднээс төсөв, мөнгө, гадаад худалдааны зохистой бодлого хэрэгжүүлнэ. | 2004-2006 | Н.Баяртсайхан<br>О.Чулуунбат<br>Б.Жаргалсайхан |
| | | | 2. Хэрэглээний барааны үнийн өсөлтийн талаар иргэдийн дунд санал асуулга явуулах, хэрэглээний барааны үнийн индексийг тооцох аргачлалыг сайжруулах талаар Үндэсний Статистикийн газартай хамтран ажиллана. | 2004-2006 | О.Чулуунбат<br>П.Бямбацэрэн |
| 134 | 3.1.2 | Улсын валютын нөөцийг эрсдэлд орохоос сэргийлэх арга хэмжээ авна. Гадаад валютын цэвэр нөөцийг импортын барааны 17-гоос доошгүй долоо хоногийн хэрэгцээг хангах хэмжээнд хүргэх бодлого баримтална. | 1. Улсын гадаад валютын нөөцийн удирдлагыг сайжруулж, гадаад валютын цэвэр нөөцийг жил тутам нэмэгдүүлж 2008 онд импортын 17-оос доошгүй долоо хоногийн хэрэгцээг хангах хэмжээнд хүргэнэ. | 2004-2008 | Н.Баяртсайхан<br>О.Чулуунбат<br>Б.Жаргалсайхан |
| | | | 2. Валютын нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор экспортын шинэ эх үүсвэрийг бий болгоно. | 2006-2008 | Н.Баяртсайхан<br>Б.Жаргалсайхан |
| | | | 3. Гадаад валютын нөөцийг байршуулах гадаадын банк санхүүгийн байгууллагуудын жагсаалт, тэдгээрт олгох лимитүүдийг улирал бүр шинэчлэн баталж мөрдөнө. | Улирал бүр | О.Чулуунбат |
| | | | 4. Гадаадын хөндлөнгийн байгууллагаар гадаад валютын нөөцийн байдалд тусгайлсан хяналт хийлгэнэ. | Жилд нэг удаа | О.Чулуунбат |
| | | | 5. ОУВС-тай хамтран хэрэгжүүлж байгаа "Ядуурлыг бууруулах өсөлтийг хангах хөтөлбөр"-ийн хүрээнд тохиролцсон хэмжээнд гадаад валютын нөөцийг хангаж ажиллана. | Улирал бүр | О.Чулуунбат |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 135 | 3.1.3 | Төсвийн зарцуулалтын үр ашгийг дээшлүүлж, төсвийн нийт алдагдлыг дотоодын нийт бүтээгдэхүүний 3 хувиас хэтрүүлэхгүй байх замаар эдийн засгийн тогтвортой байдлыг хангана. | 1. Засгийн газрын удирдлага, мэдээллийн системийг нэвтрүүлж бүх аймаг, нийслэлийг хамруулснаар төсвийн зарцуулалтын үр ашгийг дээшлүүлж, урсгал хяналт, санхүүгийн сахилга, тайлагналтыг сайжруулна. | 2005 оноос | Н.Баяртсайхан Төсвийн ерөнхийлөн захирагч нар |
| | | | 2. Нийт төсвийн байгууллагад амлалтын бүртгэл нэвтрүүлж батлагдсан төсвийг зориулалтын дагуу ашиглах нөхцөлийг бүрдүүлнэ. | 2005 оноос | Н.Баяртсайхан Төсвийн ерөнхийлөн захирагч нар |
| | | | 3. Төсвийн ерөнхийлөн захирагч нарын улирал, жилийн тайлангийн гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулан төсвийн байгууллагуудын өрийг өмнөх оны гүйцэтгэлээс бууруулж авлагыг барагдуулах арга хэмжээ авна. | 2005 оноос | Н.Баяртсайхан Төсвийн ерөнхийлөн захирагч нар |
| | | | 4. Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн төсвийн багцынхаа гүйцэтгэлийн тайланг нэгтгэн гаргаж байх нөхцөлийг хангуулж, 2004 оны төсвийн гүйцэтгэлийн жилийн эцсийн тайлангаас эхлэн туршиж, цаашид мөрдөж ажиллана. | 2005 оноос | Н.Баяртсайхан Төсвийн ерөнхийлөн захирагч нар |
| | | | 5. Төрийн захиргааны болон төсвийн байгууллагуудад нийтлэг үйлчилгээний нэгдсэн бодлого, зохицуулалтын арга механизмыг хэрэгжүүлэн ажиллаж, төсвийн зарцуулалтын үр ашгийг дээшлүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ. | 2005-2008 | С.Батболд Н.Баяртсайхан |
| | | | 6. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж төсвийн хөрөнгө оруулалт бараа, үйлчилгээний зарлагын үр ашгийг сайжруулах боломжийг нэмэгдүүлнэ. | 2005-2008 | Н.Баяртсайхан |
| | | | 7. Улсын болон орон нутгийн төсвөөс санхүүждэг байгууллагын төсвийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулж, үр ашигтүй зардлыг багасгах арга хэмжээ авна. | 2005-2008 | У.Хүрэлсүх |
| 136 | 3.1.4 | Аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг нэг шатлалд шилжүүлнэ. | 1. Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварыг нэг шатлалд шилжүүлэхтэй холбогдсон судалгаа хийж, санал боловсруулан нэг шатлалд шилжүүлнэ. | 2005 оноос | Н.Баяртсайхан Б.Жаргалсайхан |
| 137 | 3.1.5 | Импортын татварын болон дотоодын зах зээлийг хямралаас урьдчилан сэргийлэх, хамгаалах зохистой бодлого баримтална. | 1. Дотоодын үйлдвэрүүдийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэн татварын уян хатан бодлогоор дэмжинэ. | 2006-2008 | Н.Баяртсайхан Б.Жаргалсайхан |
| | | | 2. Дотоодод үйлдвэрлэж байгаа бараа бүтээгдэхүүнтэй ижил төстэй импортын бараанд ногдуулах гаалийн татварыг Дэлхийн худалдааны байгууллагын өмнө хүлээсэн үүргийн хүрээнд шинэчлэн тогтоох талаар санал боловсруулна. | 2005 | Б.Жаргалсайхан |
| | | | 3. Согтууруулах ундааны үйлдвэрүүдэд хяналтын тоолуур суурилуулж, бүтээгдэхүүнд ногдуулж байгаа онцгой албан татварын системийг боловсронгуй болгоно. | 2005-2008 | Д.Тэрбишдагва Н.Баяртсайхан |
| | | | 4. Тамхины үйлдвэрлэлтэй холбоотой эрх зүйн орчинг боловсронгуй болгоно. | 2005-2008 | Д.Тэрбишдагва |
| | | | 5. Импортын татварыг ялгавартай тогтоох бодлого боловсруулна. | 2005 | Б.Жаргалсайхан Н.Баяртсайхан |
| | | | 6. Импортыг орлох бүтээгдэхүүний судалгааг гаргаж, түүний үндсэн дээр дотоодын үйлдвэрлэлийг дэмжих талаар санал боловсруулна. | 2005 | Б.Жаргалсайхан Д.Тэрбишдагва |
| 138 | 3.1.6 | Малчин өрхийн орлого, амьжиргааны түвшинд уялдсан татварын уян хатан бодлогыг хэрэгжүүлнэ. | 1. Малчин өрх, мал бүхий иргэдийн орлого, амьжиргааны түвшинтэй уялдуулан татварын эрх зүйн үндсийг боловсронгуй болгоно. | 2005-2008 | Д.Тэрбишдагва Н.Баяртсайхан |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 139 | 3.1.7 | Тегрегийн гадаадад хөрвөх чадварыг бэхжүүлнэ. | 1. Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш нь банк хоорондын валютын эрэлт, нийлүүлэлтийн дагуу чөлөөтэй тогтох хөвөх ханшны тогтолцоог үргэлжлүүлнэ. | Жил бүр | О.Чулуунбат |
| 140 | 3.1.8 | Зээл, тусламжийн зарцуулалтын үр ашгийг дээшлүүлж, түүнд тавих хяналтыг сайжруулна. | 1. Зээл, тусламжийн хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор холбогдох журмуудыг боловсруулж батлуулна. | 2005-2008 | Н.Баяртсайхан |
| | | | 2. Эдийн засгийн хувьд үр ашигтай нь нотлогдсон, зээлийн үндсэн төлбөр болон хүүгийн төлбөрийг бүрэн төлөх боломжтой төсөлд гадаадаас зээл түлхүү авах тогтолцоонд шилжинэ. | 2005-2008 | Н.Баяртсайхан |
| | | | 3. Өрийн удирдлагын стратегийг ОУВС, Дэлхийн банк, Азийн хөгжлийн банктай хамтран боловсруулж эрх бүхий байгууллагаар батлуулна. | 2005-2008 | Н.Баяртсайхан |
| | | | 4. Өрийн удирдлагын систем буюу DSM+программ хангамжийг иж бүрэн нэвтрүүлж ашиглана. | 2005-2008 | Н.Баяртсайхан |
| | | | 5. Иргэд, аж ахуйн нэгжүүдэд дамжуулан зээлдүүлсэн зээлийн эргэн төлөлтийг сайжруулах чиглэлээр эрх зүйн орчинг боловсронгуй болгоно. | 2005-2008 | Н.Баяртсайхан |
| | | | 6. Түлш, эрчим хүчний салбарт хэрэгжүүлж байгаа төслийн үр дүн, үр ашгийг тооцож, шинээр хэрэгжүүлэх төслийг үр ашиг, ач холбогдолтой нь уялдуулан зээл тусламжид хамруулна. | 2005-2008 | Б.Эрдэнэбат |
| 141 | 3.1.9 | Шударга бус өрсөлдөөнийг хориглох, дэнгээр ноёрхлыг хязгаарлах үр дүнтэй тогтолцоог бий болгоно. | 1. Шударга бус өрсөлдөөнийг хянан зохицуулах бодлогын хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлнэ. | 2005 оноос | М.Энхсайхан |
| 142 | 3.1.10 | Дампуурал болон тусгай зөвшөөрлийн эрх зүйн орчны шинэтгэлийг гүнзгийрүүлнэ. | 1. Дампуурлын тухай хуулийг шинэчлэн боловсруулна. | 2005- 2006 | Д.Одбаяр |
| | | | 2. Тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхэлж байгаа аж ахуйн үйл ажиллагааны талаарх хууль тогтоомжийг судалсны үндсэн дээр цаашид авах арга хэмжээний санал боловсруулна. | 2005– 2006 | Д.Одбаяр<br>Б.Жаргалсайхан |
| | | | 3. Банк, банк бус санхүүгийн байгууллагын дампуурлын талаарх эрх зүйн зохицуулалтыг судалж, санал боловсруулна. | 2005 | О.Чулуунбат |
| **3.2. Банк, санхүүгийн салбарыг бэхжүүлэх хүрээнд:** | | | | | |
| 143 | 3.2.1 | Санхүүгийн зах зээл, зуучлалын үйлчилгээг иж бүрнээр хөгжүүлнэ. | 1. Эдийн засгийн бүх салбарын нягтлан бодох бүртгэлийг олон улсын стандартад шилжүүлж дуусгана. | 2005-2008 | Н.Баяртсайхан |
| | | | 2. Аудитын үйл ажиллагааг чанарын шинэ шатанд гаргаж, олон улсын жишигт хүргэнэ. | 2005-2008 | Н.Баяртсайхан |
| | | | 3. Хөрөнгийн үнэлгээний эрх зүйн орчныг бүрдүүлэн, үнэлгээний ажлын удирдлага, хяналтыг бий болгоно. | 2005-2008 | Н.Баяртсайхан |
| | | | 4. Банк, санхүүгийн шинэ төрлийн үйлчилгээг нэвтрүүлэх, орон нутагт банк, санхүүгийн үйлчилгээг илүүтэйгээр хүргэхэд анхаарна. | 2005-2008 | Н.Баяртсайхан<br>О.Чулуунбат |
| | | | 5. Санхүүгийн зах зээлд шударга бус өрсөлдөөнтэй тэмцэх ажлыг эхлүүлнэ. | 2005 оноос | М.Энхсайхан<br>О.Чулуунбат<br>Н.Баяртсайхан |
| 144 | 3.2.2 | Олон улсын санхүүгийн зах зээлд Засгийн газрын бонд гаргана. | 1. Олон улсын хөрөнгө оруулалтын банкуудтай хамтран үнэт цаас гаргах боломжийг судалж, Засгийн газрын бонд гаргах ажлын төлөвлөгөө боловсруулна. | 2005-2008 | Н.Баяртсайхан<br>О.Чулуунбат |
| | | | 2. Олон улсын хөрөнгө оруулалтын банкуудтай хамтран үнэт цаас гаргах боломжийг судалж журамлах арга хэмжээ авна. | 2005-2008 | Н.Баяртсайхан |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 145 | 3.2.3 | Санхүү, мөнгөний таатай, өрсөлдөх чадвар бүхий бүсүүдийг бий болгох эрх зүйн орчинг бүрдүүлнэ. | 1. Орон нутаг дахь мөнгө, санхүүгийн байдлыг судалж, холбогдох байгууллагуудтай хамтран ажиллана.<br>2. Санхүү, мөнгөний таатай, өрсөлдөх чадвар бүхий бүсүүдийг бий болгохтой холбогдсон эрх зүйн орчныг судалж, холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг боловсруулна. | 2004-2006<br>2005 | О.Чулуунбат<br>О.Чулуунбат |
| 146 | 3.2.4 | Зээлийн хүүг бууруулах шат дараалсан арга хэмжээг мөнгө, төсөв, татварын бодлогоор дамжуулан хэрэгжүүлнэ. | 1. Эдийн засаг дахь хүүгийн түвшин болон түүнийг бууруулах боломжийг мөнгө, төсөв, татварын бодлоготой уялдуулан судалж хэрэгжүүлнэ. | 2004-2005 | О.Чулуунбат<br>Н.Баяртсайхан |
| 147 | 3.2.5 | Үнэт цаасны хоёр дахь зах зээлийг идэвхжүүлнэ. | 1. Үнэт цаасны зах зээлийг хөгжүүлэх эрх зүйн орчинг боловсронгуй болгоно.<br>2. Үнэт цаасны зах зээлд оролцогчдыг дэмжих зорилгоор орлогын албан татварын хөнгөлөлт үзүүлнэ.<br>3. Зах зээлд давамгай байдлыг бий болгохгүйн тулд үнэт цаасны гүйлгээнд хяналт тавьж ажиллана. | 2005-2007<br>2005-2008<br>2005-2008 | Д.Бадраа<br>Н.Баяртсайхан<br>Д.Бадраа<br>М.Энхсайхан<br>Д.Бадраа |
| 148 | 3.2.6 | Урт хугацааны зээл, ипотекийн аргыг нэвтрүүлэх замаар иргэдийг орон сууцаар хангах ажлыг эрчимжүүлнэ. Ипотекийн үнэт цаасны хоёрдогч зах зээлийг бий болгож, идэвхжүүлнэ. | 1. Ипотекээр баталгаажсан үнэт цаасны зах зээлийг хөгжүүлэхэд шаардлагатай эрх зүйн орчныг бүрдүүлж иргэдэд орон сууцаа барьцаалан урт хугацаатай зээл авах санхүүгийн тогтолцоог бий болгож, үл хөдлөх хөрөнгө, орон сууцыг арилжааны хэрэгсэл болгох эрх зүйн орчин бүрдүүлнэ.<br>2. Урт хугацаат зээл, ипотекийн аргыг нэвтрүүлэх замаар иргэдийг орон сууцаар хангах ажлыг эрчимжүүлнэ.<br>3. Үл хөдлөх хөрөнгийг барьцаалсан зээлээр баталгаажсан үнэт цаасны зах зээлийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлж, холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, шинээр хууль боловсруулах замаар ипотекийн үнэт цаасны хоёрдогч зах зээлийн эрх зүйн орчныг бүрдүүлнэ. | 2005-2006<br>2004-2006<br>2005-2008 | Ж.Наранцацралт<br>Д.Одбаяр<br>О.Чулуунбат<br>Н.Баяртсайхан<br>Ж.Наранцацралт<br>Д.Бадраа |
| 149 | 3.2.7 | Төлбөр тооцоог бэлэн бусаар болон электрон хэлбэрээр хийх боломжийг өргөтгөнө. | 1. Төлбөр тооцоог бэлэн бусаар хийх дэд бүтцийг бүрдүүлэх зорилгоор банк хоорондын картын свич/клирингийн төвийг байгуулж, үйл ажиллагааг эхлүүлнэ.<br>2. Төсвийн байгууллагуудад ажиллагсдын цалинг картаар олгуулах ажлыг эрчимжүүлж орон нутгийн төсвийн байгууллагуудыг хамруулна. | 2005<br>2005-2008 | О.Чулуунбат<br>Н.Баяртсайхан |
| 150 | 3.2.8 | Иргэний хувийн дансны нууцлалыг чангатгана. Хувийн дансны нууцлалыг онцгой, өндөр нөхцөлөөр хуульчлан хамгаална. | 1. Иргэдийн хувийн дансны нууцлалыг сайжруулахтай холбогдсон эрх зүйн зохицуулалтыг судалж, холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах асуудал боловсруулна. | 2005 | О.Чулуунбат |
| 151 | 3.2.9 | Иргэдийн зээлийн түүхийн тогтолцоог бий болгохыг дэмжиж ажиллана. | 1. Монголбанкны Зээлийн мэдээллийн санд хадгалагдаж байгаа мэдээлэлд үндэслэн зээлдэгчийн талаарх мэдээллийг түүхчилсэн байдлаар хадгалах боломжийг бүрдүүлнэ. | 2005 | О.Чулуунбат |
| **3.3. Хувьчлалыг үргэлжлүүлж газар болон хөрөнгийн эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлнэ. Энэ зорилтын хүрээнд:** | | | | | |
| 152 | 3.3.1 | Газрын шинэтгэлийг эрчимжүүлнэ. | 1. Газрын нэгдмэл сангийн тоо бүртгэл, зураглалын ажлыг орчин үеийн газар зүйн мэдээллийн системийн шаардлагад нийцүүлэн боловсруулах ажлыг зохион байгуулна.<br>2. Газар өмчлөлийн явцад дүн шинжилгээ хийж, иргэн бүрт газар өмчлүүлэх, газрыг оновчтой төлөвлөх, хуваарилах, бэлчээр эзэмшүүлэх, ашиглуулах аргыг судалж бодлогын хүрээнд хэрэгжүүлнэ. | 2005-2008<br>2005-2008 | Ж.Наранцацралт<br>Ж.Наранцацралт<br>Д.Тэрбишдагва |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | 3. Газрын төлөв байдлын өөрчлөлтөд төрийн хяналт тогтоох зорилгоор газрын хянан баталгааны судалгааг үргэлжлүүлэн зохион байгуулж "Газрын мониторингийн сүлжээ" үндэсний хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ. | 2005-2008 | Ж.Наранцацралт |
| | | | 4. Газрыг доройтлоос хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулж байгаа хөрөнгийн үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор нөхөн сэргээлтийн ажлын арга зүй, стандартыг шинэчилнэ. | 2005-2008 | Ж.Наранцацралт |
| | | | 5. Улсын нийт нутаг дэвсгэрийг хамарсан GPS-ийн сүлжээг өтгөрүүлэх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэн дунд болон том масштабын байр зүйн зургийг нэгдсэн нэг системд гүйцэтгэх нөхцөлийг бий болгоно. | 2005-2008 | Ж.Наранцацралт |
| 153 | 3.3.2 | Газрын өмчлөлийн мэдээлэл, бүртгэлийг иргэдэд нээлттэй байлгаж үйлчилгээг шуурхай болгоно. | 1. Мэдээлэл, холбооны сүлжээг ашиглан үндэсний газрын мэдээллийн санг бий болгож бүс нутгийн хөгжил, хот байгуулалт, газар зохион байгуулалтын ажлын уялдааг хангаж, мэдээллээр хөнгөн шуурхай үйлчлэх боломжийг бүрдүүлнэ. | 2005-2008 | Ж.Наранцацралт С.Батболд |
| 154 | 3.3.3 | Иргэн, үл хөдлөх хөрөнгө, байршил, аж ахуйн нэгжийн бүртгэлийн тогтолцоог боловсронгуй болгоно. | 1. Хөрөнгийн эрхийн бүртгэлийг байршлын кодоор зохицуулах тогтолцоог бий болгоно. | 2005-2008 | Ж.Наранцацралт |
| 155 | 3.3.4 | Газрын байршлын нэгдсэн кодод шилжинэ. Байршлын кодоор дамжуулан үл хөдлөх хөрөнгийн үнэлэмжийг тогтооно. | 1. Газрын байршлын нэгдсэн кодод үндэслэсэн газрын болон газрын кадастр, хөрөнгийн эрхийн бүртгэлийн мэдээллийн санг үндэсний болон орон нутгийн түвшинд байгуулах хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлнэ. | 2005-2008 | Ж.Наранцацралт |
| | | | 2. Газрын судалгаа шинжилгээний дунд бий болсон нийт аймаг сумдын нутаг дэвсгэрийг хамарсан хөрс, ургамал, газрын бүрхэвч, гадаргын ус зүй болон газрын данс бүртгэл зураг цаасан дээр байгаа тоон болон зурган хэлбэрийн орон зайн мэдээллийг байршлын нэгдсэн кодтой уялдуулан тоон мэдээлэлд хөрвүүлэх ажлыг зохион байгуулна. | 2005-2008 | Ж.Наранцацралт |
| 156 | 3.3.5 | Үл хөдлөх хөрөнгийн татварыг боловсронгуй болгоно. | 1. Үл хөдлөх хөрөнгийн татвар ногдуулдаг олон улсын нийтлэг жишгийг судлан өөрийн орны онцлогт тохируулан хэрэгжүүлэх арга хэмжээ авч, энэ талаар холбогдох хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулна. | 2005-2006 | Ж.Наранцацралт Н.Баяртсайхан |
| 157 | 3.3.6 | Газрын төлбөрийн хэмжээг газрын үр өгөөж, байршилтай уялдуулж ялгавартай тогтооно. | 1. Газрын үнэлгээний аргачлалыг боловсронгуй болгосны үндсэн дээр үл хөдлөх хөрөнгө болон газрын төлбөрийн хэмжээг газрын үр өгөөж, байршлыг нь харгалзан ялгавартай шинэчлэн тогтоож боловсронгуй болгоно. | 2005-2008 | Ж.Наранцацралт Н.Баяртсайхан |
| | | | 2. Газрын төлбөрийн тухай болон хүн амын орлогын албан татварын тухай хуульд газрыг үр ашигтай ашиглагчдыг урамшуулах, ашиглахгүй байгаа болон хөрсний үржил шимийг бууруулахыг хязгаарлах талаар холбогдох нэмэлт, өөрчлөлт оруулна. | 2005-2008 | Д.Тэрбишдагва Ж.Наранцацралт Н.Баяртсайхан |
| | | | 3. Бэлчээр ашиглалтын төлбөрийг малын төрөл, ашиг шимийн чиглэл, экологид нөлөөлөх байдал, бүс нутгийн онцлогтой уялдуулсан эрх зүйн орчинг бүрдүүлнэ. | 2005-2006 | Д.Тэрбишдагва |
| | | | 4. Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого, эрчимжсэн мал аж ахуйг дэмжих хөтөлбөрт заасан бэлчээрийг эзэмшүүлэх чиглэлээр Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулна. | 2005-2006 | Д.Тэрбишдагва Ж.Наранцацралт |
| 158 | 3.3.7 | Хувьчлалын арга хэлбэрийг өргөтгөж, үр ашгийг нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ. Үнэ цэнэ бүхий томоохон аж ахуйн нэгжүүдийн хувьчлалыг үргэлжлүүлнэ. | 1. Төрийн өмчийг 2005-2008 онд хувьчлах үндсэн чиглэлийг боловсруулж, УИХ-аар батлуулна. | 2005 | С.Батболд Сайд нар |
| | | | 2. Төрийн өмчийг 2005-2008 онд хувьчлах үндсэн чиглэлийн хүрээнд Төрийн өмчийг хувьчлах хөтөлбөрийг жил бүр Засгийн газраас батлан хэрэгжүүлнэ. | 2005 | С.Батболд Сайд нар |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | 3. Нийтийн аж ахуйн салбарыг хувьчлах хөтөлбөрийн хүрээнд Төв, Өвөрхангай, Дундговь, Булган аймгууд болон Улаанбаатар, Эрдэнэт, Дархан хотын ус суваг, Нийтийн аж ахуйн байгууллагуудын менежментийн хувьчлалыг үргэлжлүүлнэ. | 2005-2008 | Ж.Наранцацралт |
| | | | 4. Менежментийн гэрээгээр ажиллаж байгаа байгууллагуудын үр дүнг дүгнэж үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлно. | 2005-2008 | Ж.Наранцацралт<br>Сайд нар |
| | | | 5. Томоохон аж ахуйн нэгжүүдийн хувьчлалд Шударга бус өрсөлдөөнийг хянан зохицуулах газар санал өгдөг тогтолцоонд шилжих асуудлыг шийдвэрлүүлнэ. | 2005 | М.Энхсайхан<br>С.Батболд |
| 159 | 3.3.8 | Нийгмийн салбарт менежментийн хувьчлалыг түлхүү ашиглана. | 1. Нийгмийн салбарт өөрчлөлт, шинэчлэл, хувьчлал хийх үндсэн чиглэлийг батлан хэрэгжүүлнэ. | 2005 | С.Батболд<br>Ө.Энхтүвшин<br>Л.Гүндалай |
| 160 | 3.3.9 | Тендерийн журмыг боловсронгуй болгож үйлчилгээний ил тод байдлыг хангана. | 1. Өмч хувьчлалыг олон нийтэд ил тод байлгах хүнд суртлыг арилгах зорилгоор нийцүүлэн одоогийн мөрдөгдөж байгаа өмч хувьчлалын журмуудыг өөрчлөн мөрдүүлнэ. | 2005 | С.Батболд |
| | | | 2. Хувьчлалыг хэрэгжүүлж байгаа байгууллага өрсөлдөөнт тендер шалгаруулалт явуулахдаа холбогдох хууль журмуудыг мөрдөж, хувьчлалын үйл ажиллагааны ил тод, үр ашигтай, шударга байдлыг хангана. | 2005-2008 | С.Батболд<br>Сайд нар |
| **3.4. Үйлдвэрлэл, хөдөө аж ахуй, үйлчилгээний салбарыг дэмжиж, экспортыг нэмэгдүүлэх хүрээнд:** | | | | | |
| 161 | 3.4.1 | Төрөөс үйлдвэрлэл, үйлчилгээ, хөрөнгө оруулалтыг дэмжих бодлого боловсруулахад мэргэжлийн холбоодын идэвхтэй оролцоог хангах механизм бий болгоно. | 1. Салбарын мэргэжлийн холбоодын нэгдсэн зөвлөл байгуулж, үйл ажиллагааг нь эхлэхэд дэмжлэг үзүүлнэ. | 2005 | Б.Жаргалсайхан |
| | | | 2. Олон улсын жишгээр бизнесийн орчинд нөлөөлөх хууль, шийдвэрийн төслийн талаар Салбарын мэргэжлийн холбоодын нэгдсэн зөвлөлтэй тогтмол зөвлөлдөж байх тогтолцоог бүрдүүлнэ. | 2005 | Б.Жаргалсайхан |
| 162 | 3.4.2 | Эдийн засаг, худалдааны чөлөөт бүс байгуулах бодлогыг үргэлжлүүлж өргөтгөнө. | 1. Чөлөөт бүсийн тухай хуулийн дагуу "Алтанбулаг", "Замын-Үүд", "Цагааннуур"-ын чөлөөт бүсийн Захирагчийг томилон, тэдгээрийн ажлын албыг шинэчлэн зохион байгуулж, чөлөөт бүсийн эдийн засаг, санхүүгийн зохицуулалтыг боловсронгуй болгоно. | 2005-2006 | Б.Жаргалсайхан<br>Н.Баяртсайхан<br>М.Энхсайхан |
| | | | 2. Чөлөөт бүсүүдийн мастер төлөвлөгөө, хөрөнгө оруулалтын төслүүдийн эдийн засгийн үндэслэлийг сайжруулж, тэргүүлэх чиглэлийн зорилтыг дотоод, гадаадын хөрөнгө оруулалттай холбон хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. | 2005-2008 | Б.Жаргалсайхан<br>Н.Баяртсайхан |
| | | | 3. "Алтанбулаг" худалдааны чөлөөт бүсийн үйл ажиллагааг эхлүүлж, эрчимжүүлэх арга хэмжээ авна. | 2005-2008 | Б.Жаргалсайхан |
| | | | 4. "Замын-Үүд" эдийн засгийн чөлөөт бүсийн үйл ажиллагааг эхлүүлж, эрчимжүүлэх арга хэмжээ авна. | 2005-2008 | Б.Жаргалсайхан |
| | | | 5. Бэлтгэл ажлыг хангасны дараа "Цагааннуур" худалдааны чөлөөт бүсийн үйл ажиллагааг эхлүүлнэ. | 2005-2008 | Б.Жаргалсайхан |
| | | | 6. Худалдаа, эдийн засгийн чөлөөт бүсийн эрх зүйн орчинг боловсронгуй болгох арга хэмжээ авна. | 2005-2006 | Б.Жаргалсайхан |
| | | | 7. Хөрөнгө оруулагчид, бизнес эрхлэгчдэд үйлчлэх мэдээллийн бааз, сүлжээ байгуулна. | 2005-2008 | Б.Жаргалсайхан |
| | | | 8. Улаанбаатар, Дархан, Эрдэнэт, Чойр хотууд, Налайх дүүрэгт "Үйлдвэрлэл, технологийн парк" байгуулах талаар судалгаа хийж, хэрэгжүүлэх арга хэмжээ авна. | 2005-2008 | Б.Жаргалсайхан |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 163 | 3.4.3 | Жижиг, дунд үйлдвэрийг дэмжихэд чиглэсэн үйлдвэрлэл-технологийн парк байгуулна. | 1. Зуунмод, Чойбалсан, Улиастай, Багануур, Сүхбаатар, Ховд хот, Багахангай дүүрэгт "Үйлдвэрлэл технологийн парк" байгуулах хөтөлбөр, төсөл боловсруулж, гадаад орнуудад сурталчлах арга хэмжээ авна. | 2005-2008 | Б.Жаргалсайхан |
| | | | 2. Ноолуурын үйлдвэрүүдэд дагналт, хоршилтын бодлого явуулж, сүлжих, гүйцэтгэн борлуулах шинэ хүчин чадлыг бий болгох санал, төсөл боловсруулж, хэрэгжүүлэх алхам хийнэ. | 2006-2008 | Б.Жаргалсайхан |
| | | | 3. Нэхий, шевро, шеврет, булигаарын үйлдвэрлэлийн боловсруулах хүчин чадал, эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх санал, төсөл боловсруулж, хэрэгжүүлэх арга хэмжээ авна. | 2006-2008 | Б.Жаргалсайхан |
| 164 | 3.4.4 | Экспортын чиглэлийн болон оюуны багтаамж ихтэй үйлдвэрлэлийг дэмжинэ. | 1. Үр ашигтай, оюуны багтаамж ихтэй үйлдвэрлэлийг дэмжих журам гаргаж мөрдүүлнэ. | 2005-2008 | Б.Жаргалсайхан<br>Ө.Энхтүвшин |
| | | | 2. Молибдений исэл үйлдвэрлэх, катодын зэсийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, шинэ хүчин чадлыг бий болгох төсөл, үйл ажиллагааг дэмжиж ажиллана. | 2006-2008 | Б.Жаргалсайхан |
| | | | 3. Экспортын бүтээгдэхүүнд хэрэглэгддэг импортын түүхий эдийг гаалийн татвараас чөлөөлөх асуудлыг боловсруулж, татварын багц хуулийн шинэтгэлийн хүрээнд шийдвэрлүүлэх арга хэмжээ авна. | 2005 | Б.Жаргалсайхан |
| | | | 4. Эрдэнэт, Дархан хотуудад хүнд үйлдвэрийг хөгжүүлэх хөтөлбөр, төслүүдийг боловсруулна. | 2006-2008 | Б.Жаргалсайхан |
| | | | 5. Дотоодын мэдээллийн технологи, программ хангамжийн чиглэлээр ажиллаж буй байгууллага, компаниудын бүтээгдэхүүн, үйлчилгээг гадаад зах зээлд нийлүүлэхэд чиглэсэн санал санаачилгыг дэмжинэ. | 2005-2008 | Б.Жаргалсайхан |
| | | | 6. Компьютер, электроник, цахилгаан холбооны тоног төхөөрөмжийн үндсэний үйлдвэрлэл болон дотоодын программ хангамжийн зах зээлийг хөгжүүлэхэд программ хангамжийн захиалга, төслүүдийг дотоодын компаниудаар гүйцэтгүүлэх бодлогыг тулхүү баримтална. | 2005 оноос | Б.Жаргалсайхан |
| 165 | 3.4.5 | Засгийн газрын захиалгат бараа, бүтээгдэхүүнийг дотоодын үйлдвэрлэлээр хангах бодлого баримтална. | 1. Төсвийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлэхдээ дотоодын үйлдвэрийн бүтээгдэхүүнийг Засгийн газрын захиалгаар нийлүүлэх, нэмэгдүүлэх арга хэмжээ авна. | 2005-2006 | Н.Баяртсайхан<br>Б.Жаргалсайхан |
| 166 | 3.4.6 | Орон нутагт үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний хоршоодын үйл ажиллагааг дэмжсэн тогтолцоог боловсронгуй болгоно. | 1. Хөдөө аж ахуйн хөрөнгө оруулалтыг орон нутгийн захиргаа, иргэн, аж ахуйн нэгжийн эрэлт хэрэгцээ, санаачилга оролцоонд үндэслэн хэрэгжүүлнэ. | 2005-2008 | Д.Тэрбишдагва |
| | | | 2. Фермерүүдийн үйлчилгээ, борлуулалт, хангамжийн хоршоодыг дэмжинэ. | 2005-2008 | Д.Тэрбишдагва |
| | | | 3. "Бөөний худалдааны сүлжээ" хөтөлбөрийг хэрэгжүүлж үйл ажиллагааг нь боловсронгуй болгоно. | 2005-2008 | Б.Жаргалсайхан |
| | | | 4. Олон улсын нэр хүнд бүхий бөөний худалдааны сүлжээг Монголд нэвтрүүлэх боломжийг судалж, хэрэгжүүлэх арга хэмжээ авна. | 2005-2008 | Б.Жаргалсайхан |
| | | | 5. Худалдааны зохицуулалтын тухай хуулийн төслийг боловсруулж, батлуулна. | 2005-2008 | Б.Жаргалсайхан |
| | | | 6. Бөөний болон жижиглэн худалдааны үйлчилгээний стандартыг сайжруулан, шинэчлэн боловсруулж, мөрдүүлэх арга хэмжээ авна. | 2005-2008 | Б.Жаргалсайхан |
| 167 | 3.4.7 | Фермерийн болон эрчимжсэн хөдөө аж ахуйг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлнэ. | 1. Фермерийн аж ахуй хөгжүүлэх эрх зүй, эдийн засгийн таатай орчин бүрдүүлнэ. | 2005-2006 | Д.Тэрбишдагва |
| | | | 2. Эрчимжсэн хөдөө аж ахуйн хөгжлийг дэмжих засгийн газрын хөтөлбөрийг хэрэгжүүлэх чадавхи бүрдүүлэх, малын үр хөврөл бэлдэх орчин үеийн лаборатори, зохиомол хээлтүүлгийн станцуудыг эрчимжсэн мал аж ахуй эрхлэх бүс нутгуудад байгуулна. | 2005-2008 | Д.Тэрбишдагва |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 168 | 3.4.8 | Жижиг, дунд үйлдвэр, фермерийн аж ахуйг дэмжих зорилгоор жижиг зээлийн үйлчилгээний хүрээг өргөтгөж, үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, хөдөө аж ахуйн техник, төхөөрөмжийг урт хугацаатай, бага хүүтэй зээл, түрээс, лизинг болон төлбөрт үйлчилгээний хэлбэрийг дэмжинэ. | 1. Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж байгаа иргэн, хуулийн этгээдийн үйлдвэрлэлийн хэмжээ, зориулалт, чиглэлд нийцсэн хүчин чадалтай техник хэрэгслийг урт хугацаатай, бага хүүтэй зээл, лизингээр олгох, өөртөө техникгүй жижиг аж ахуйн нэгж, иргэнд зориулсан механикжсан ажлын төлбөрт үйлчилгээ эрхлэгчдэд санхүүгийн дэмжлэг үзүүлж, гадаад, дотоодын зээл тусламжийг түлхүү ашиглана. | 2005-2008 | Д.Тэрбишдагва |
| | | | 2. Мал аж ахуй, газар тариаланг хослон эрхлэж байгаа 8000-аас доошгүй иргэн, аж ахуйн нэгжид бага оврын трактор, цахилгаан үүсгүүр, хадлангийн болон газар тариалангийн техник хэрэгслийг хөнгөлөлттэй үнээр нийлүүлэх арга хэмжээ авна. | 2005-2008 | Д.Тэрбишдагва |
| | | | 3. Тоног төхөөрөмжийн лизингийн үйлчилгээнд үнийн дүнгийн 25.0 хувь хүртэл хэмжээнд санхүүгийн баталгаа гаргах асуудлыг Монголбанктай хамтран шийдвэрлэх арга хэмжээ авна. | 2005-2008 | Б.Жаргалсайхан<br>О.Чулуунбат |
| | | | 4. Орон нутагт "Жижиг, дунд үйлдвэрт зөвлөгөө өгөх албо" байгуулах төслийг олон улсын хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ авна. | 2005-2008 | Б.Жаргалсайхан |
| | | | 5. Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх санхүү, зээлийн бодлогыг боловсронгуй болгох санал боловсруулж хэрэгжүүлэх арга хэмжээ авна. | 2005-2008 | Б.Жаргалсайхан<br>Н.Баяртсайхан |
| | | | 6. Лизингийн эрх зүйн орчин бүрдүүлнэ. | 2007 | Б.Жаргалсайхан |
| 169 | 3.4.9 | Манай орны байгаль, цаг уурын өвөрмөц нөхцөлд газар тариалангийн үйлдвэрлэлийг эрчимжүүлэх үндсэн хэлбэр нь усалгаатай тариалан хэмээн үзэж, усалтын системийн барилга байгууламжийг шинэчлэх, засварлах, шинээр барьж байгуулахад чиглэсэн хөрөнгө оруулалтыг дэмжиж, гадаад, дотоодын зээл тусламжийн хөрөнгийн зохих хэсгийг түүнд чиглүүлнэ. | 1. Төрөөс газар тариалангийн салбарт олгож байгаа санхүүгийн дэмжлэгийг услалтын системүүдийг сэргээн засварлах, шинээр байгуулахад чиглүүлэн энэ чиглэлээр жил бүрийн төсөвт тодорхой хэмжээний хөрөнгийг тусгана. | 2005-2008 | Д.Тэрбишдагва |
| | | | 2. Уг асуудлыг татварын бодлогоор дэмжих эрх зүйн үндсийг бүрдүүлнэ. | 2007 | Д.Тэрбишдагва |
| | | | 3. "Газар тариаланг дэмжих сан"- гийн үйл ажиллагааны журмыг боловсруулан мөрдөж түүнийг усалгаатай тариаланг нэмэгдүүлэх, тариалангийн техник, технологийг шинэчлэх, таримлын үрийн аж ахуйг хөгжүүлэхэд түлхүү ашиглана. | 2005-2008 | Д.Тэрбишдагва |
| 170 | 3.4.10 | Усалгаатай тариалан эрхлэх, тариаланчдад газар өмчлүүлэхийг дэмжинэ. | 1. Усалгаатай тариалан эрхлэхийг бүх талаар дэмжих, усалгааны техник, тоног төхөөрөмжийг импортын НӨАТ-аас чөлөөлнө. | 2006-2008 | Д.Тэрбишдагва<br>Ж.Наранцацралт |
| 171 | 3.4.11 | Төмс, хүнсний ногоо, хүнс, тэжээлийн үет буурцагт ургамал болон сүү, сүүн бүтээгдэхүүн, жимс, жимсгэний үйлдвэрлэлийг дэмжинэ. | 1. Өрх, фермерийн аж ахуй, жижиг хоршоодын буудай, төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнийн тариалалт, сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг гааль, НӨАТ, газрын төлбөр болон зээл, хөрөнгө оруулалтын бодлогоор дэмжинэ. | 2007 | Д.Тэрбишдагва<br>Аймаг, нийслэлийн засаг дарга |
| | | | 2. Хүнс, тэжээлийн ач холбогдолтой ашигт ургамлыг таримал жуулах, таримлын нэр төрлийг нэмэгдүүлэх, үрийг нь үржүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. | 2005-2007 | Д.Тэрбишдагва<br>И.Эрдэнэбаатар |
| | | | 3. Хадлангийн талбайг сайжруулахад хэрэглэх олон наст үет буурцагт ургамлын үр үйлдвэрлэх, борлуулах, улсын нөөцийн үет, буурцагт ургамлын ээлэх жинг нэмэгдүүлнэ. | 2005-2007 | Д.Тэрбишдагва |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 172 | 3.4.12 | Бэлчээр ашиглах, эзэмших эрх зүйн таатай орчин, тогтвортой менежментийг бүрдүүлж, малын тэжээлийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, мал эмнэлэг, үржлийн ажлын чанар, хүртээмжийг сайжруулж, малын даатгалын системийг нэвтрүүлэх замаар уламжлалт мал аж ахуйн байгалийн эрсдэл даах чадавхийг бэхжүүлнэ. | 1. Бэлчээрийн тодорхой хэсгийг малчдын бүлэг, хоршоодод урт хугацаагаар гэрээгээр эзэмшүүлж түүнийг хашиж хамгаалах, услах, бордох зэргээр нөхөн сэргээх, ээлж сэлгээтэй ашиглах эрх зүйн үндсийг бүрдүүлнэ. | 2006-2007 | Д.Тэрбишдагва<br>Ж.Наранцацралт |
| | | | 2. Аймаг, сумдыг бэлчээрийн ашиглалтын зураглал хийх чадвартай болгоход гадаадын хөтөлбөр, төслийг идэвхтэй ашиглана. | 2005-2008 | Д.Тэрбишдагва<br>Н.Баяртсайхан |
| | | | 3. Малын тарималь тэжээл үйлдвэрлэл, байгалийн хадлан бэлтгэлийг нэмэгдүүлнэ. | 2005-2008 | Д.Тэрбишдагва |
| | | | 4. Мал эмнэлгийн байгууллагыг Олон улсын жишигт нийцүүлэн өөрчлөн зохион байгуулж, мал эмнэлэг, үржлийн ажлын үйл ажиллагаа, үйлчилгээг сайжруулна. | 2007 | Д.Тэрбишдагва |
| | | | 5. Мал аж ахуйн салбарын байгалийн эрсдэл даах чадавхийг сайжруулж, малын даатгалын системийг боловсронгуй болгоно. | 2006-2007 | Д.Тэрбишдагва<br>Н.Баяртсайхан |
| 173 | 3.4.13 | Монгол брэндийг өргөн нэвтрүүлнэ. Брэндийг дотоод, гадаадын зах зээлд сурталчлах зорилго бүхий үйлчилгээ, үйлдвэрлэлийг дэмжинэ. | 1. Дэлхийн оюуны өмчийн байгууллагаас жил бүр зохион байгуулагддаг үзэсгэлэнд шилдэг брэнд бүхий аж ахуй эрхлэгчдийг оролцуулах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. | 2005–2008 | Б.Жаргалсайхан<br>М.Энхсайхан |
| | | | 2. Монгол брэндийг бий болгох, хөгжүүлэхтэй холбоотой судалгаа хийж, санал, төсөл боловсруулна. | 2005-2008 | Б.Жаргалсайхан |
| 174 | 3.4.14 | "Нэг суурин–нэг бүтээгдэхүүн" хөдөлгөөнийг өрнүүлж, чанар сайтай, өрсөлдөх чадвар бүхий бүтээгдэхүүнийг шинээр бий болгож гадаад, дотоодын зах зээлд гаргахыг дэмжинэ. | 1. "Нэг сум-нэг бүтээгдэхүүн", "Нэг тосгон-нэг бүтээгдэхүүн" хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж, сурталчилна. | 2005-2008 | Б.Жаргалсайхан<br>Д.Тэрбишдагва |
| | | | 2. Орон нутагт жижиг, дунд үйлдвэрийг дэмжих чиглэлийн хүрээнд орон нутгийн онцлогт тохирсон үйлдвэрлэлийг хөгжүүлэх асуудлыг төслийн саналаар дэмжих арга хэмжээ авна. | 2005-2008 | Аймаг, нийслэлийн Засаг дарга<br>Б.Жаргалсайхан |
| 175 | 3.4.15 | Мах, сүүний боловсруулалтын түвшинг дээшлүүлж, хөдөө аж ахуйн гаралтай хүнсний бүтээгдэхүүний чанарыг сайжруулж, олон улсын стандартын түвшинд ойртуулан экспортын нэр төрлийг нэмэгдүүлнэ. | 1. Мах экспортлох гадаад зах зээлийг өргөжүүлэх зорилгоор Зүүн өмнөд Ази, Арабын орнуудтай мал эмнэлэг, ариун цэвэр, хорио цээрийн хэлэлцээр байгуулан, яам хоорондын хамтын ажиллагааг идэвхжүүлнэ. | 2005-2008 | Д.Тэрбишдагва |
| | | | 2. Мах, махан бүтээгдэхүүний чанарын шинжилгээний лабораторийг гадаадын төсөл хөтөлбөрийн хөрөнгөөр байгуулна. | 2005-2007 | Д.Тэрбишдагва |
| | | | 3. Сүү, цагаан идээг орон нутагт үйлдвэрийн аргаар боловсруулах жижиг үйлдвэрлэлийн технологи нэвтрүүлж, эрүүл ахуй, ариун цэврийн шаардлага хангасан цагаан идээний хангамжийг нэмэгдүүлнэ. | 2005-2008 | Д.Тэрбишдагва |
| 176 | 3.4.16 | Экологийн цэвэр бүтээгдэхүүн, гойд чанартай шилмэл үүлдэр, омгийн мал, амьтдын зорилтот зах зээлийг бий болгох санаачилгыг дэмжинэ. | 1. Мал сүргийн эрүүлжилтийн байдлыг хот айлын түвшинд шинжилж баталгаажуулах замаар зах зээлд борлуулах бүтээгдэхүүний эрүүл ахуй, ариун цэврийн түвшинг дээшлүүлнэ. | 2005-2008 | Д.Тэрбишдагва |
| | | | 2. Өндөр ашиг шимтэй малын үржлийн ажлыг эрчимжүүлж, үржлийн малын үзэсгэлэн худалдааг бүсчлэн зохион байгуулж арвин ашиг шимт мал, амьтдын зорилтот зах зээлийг бий болгоно. | 2005-2008 | Д.Тэрбишдагва |
| | | | 3. Экологийн цэвэр түүхий эд., биологийн идэвхит хүнсний нэмэлт бүтээгдэхүүний боловсруулалт, үйлдвэрлэлийг дэмжих эрх зүйн орчинг бүрдүүлнэ. | 2005-2008 | Д.Тэрбишдагва |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | 4. Духа ястны нийгмийн болон эрүүл мэнд, соёл иргэншлийн асуудлыг цаа буйын аж ахуйг нь сэргээн хөгжүүлэхтэй хамт иж бүрэн шийдвэрлэх дунд хугацааны хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ. | 2005-2008 | Д.Гэрбишдагва |
| | | | 5. Экологийн цэвэр бүтээгдэхүүний зах зээл бий болгох талаар "Газар зүйн заалтыг Монголд хэрэгжүүлэх" төслийг боловсруулж, Европын Холбооны комиссын санхүүгийн дэмжлэгтэйгээр хэрэгжүүлэх арга хэмжээ авна. | 2005-2008 | Б.Жаргалсайхан |
| 177 | 3.4.17 | Ашигт малтмалын орд газрын хайгуулын болон ашиглалтын лицензийн журмыг боловсронгуй болгоно. | 1. Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулж, УИХ-д өргөн барина. | 2005-2006 | Б.Жаргалсайхан |
| | | | 2. Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын лиценз олгоход Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн дагуу аймаг, нийслэлийн Засаг даргын санал авах ажиллагааг хялбаршуулах арга хэмжээг боловсруулж шийдвэрлүүлнэ. | 2005-2006 | Б.Жаргалсайхан |
| | | | 3. Хайгуулын болон ашиглалтын лиценз олголт, сунгалт, шилжүүлэлтэд мөрдөж байгаа журмуудыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд боловсронгуй болгох арга хэмжээ авна. | 2005-2006 | Б.Жаргалсайхан |
| | | | 4. Улсын төсвийн хөрөнгөөр геологи, хайгуулын ажил хийгдэж, нөөц нь тогтоогдсон орд газруудаас улс орны хөгжилд стратегийн ач холбогдолтой орд газруудыг тодорхойлж, лиценз эзэмшигчидтэй хэлцэл хийж, төрийн эзэмшлийн хувь хэмжээг тогтооно. | 2006-2007 | Б.Жаргалсайхан |
| | | | 5. Канадын 43101 болон олон улсын бусад стандарт шаардлагын дагуу геологи хайгуулын ажил явуулах, тайлан бичих, үр дүнг баталгаажуулах стандарт, арга зүйн баримт бичгийн тогтолцоог бүрдүүлнэ. | 2006-2008 | Б.Жаргалсайхан |
| | | | 6. Лиценз эзэмшигчдэд хувьцаагаа олон улсын хөрөнгийн бирж дээр гаргахад зориулсан төслийн жишиг загвар боловсруулна. | 2006-2008 | Б.Жаргалсайхан |
| 178 | 3.4.18 | Уул уурхайн үйлдвэрлэл эрхлэгчийн зүгээс байгаль орчны нөхөн сэргээлт хийх үүргийн биелэлтийг чангатгана. | 1. Нөхөн сэргээлт хийгдээгүй орхисон талбайнуудыг нөхөн сэргээлгэх арга хэмжээ авна. | 2005-2008 | Б.Жаргалсайхан<br>И.Эрдэнэбаатар<br>Н.Баяртсайхан |
| | | | 2. Олборлолт явуулж байгаа уурхайнуудын нөхөн сэргээлтийн ажилд мэргэжлийн хяналтын байгууллагатай хамтран хяналт шалгалтыг чангатгах арга хэмжээ авна. | 2005-2008 | Б.Жаргалсайхан |
| | | | 3. Уул уурхайн газрын нөхөн сэргээлтийн ажлын үр ашгийг дээшлүүлэх, зардлыг нөхөн сэргээлтийн санд төвлөрүүлэн удирдах эрх зүйн орчинг боловсронгуй болгоно. | 2005-2006 | Б.Жаргалсайхан<br>И.Эрдэнэбаатар |
| | | | 4. Нүүрс олборлох үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгжүүдийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлын төлөвлөгөөний биелэлтийг хангуулна. | 2005-2008 | И.Эрдэнэбаатар<br>Б.Эрдэнэбат<br>Б.Жаргалсайхан |
| 179 | 3.4.19 | Уул уурхайн ашигт малтмалын ордыг ашиглахдаа тухайн орон нутгийн хүн амын ахуй амьдралыг сайжруулах зорилттой уялдуулна. | 1. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн тодорхой хувийг тухайн орон нутгийн төсөвт оруулах эрх зүйн орчинг бүрдүүлнэ. | 2005-2008 | Б.Жаргалсайхан<br>Н.Баяртсайхан |
| | | | 2. Ашигт малтмалын нөөц ашигласны лизингийн төлбөрийн тодорхой хувиар орон нутгийн хөгжлийг дэмжих сан байгуулах талаар санал боловсруулна. | 2005 | Б.Жаргалсайхан<br>Н.Баяртсайхан<br>Л.Одончимэд |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 180 | 3.4.20 | Алт олборлолт, цэвэр зэсийн үйлдвэрлэлийг эрчимжүүлж, уул уурхайн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлнэ. | 1. Бороогийн алтны үйлдвэрийг бүрэн хүчин чадлаар нь ажиллуулах, Олон овоотын ордод алтны бага оврын үйлдвэрийг ашиглалтанд оруулахад дэмжлэг үзүүлнэ. | 2005 | Б.Жаргалсайхан |
| | | | 2. Алтны үндсэн ордын үйлдвэрлэлд байгаль орчинд ээлтэй шинэ технологи нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. | 2005-2006 | Б.Жаргалсайхан |
| | | | 3. Молибдений исэл үйлдвэрлэх, катодын зэсийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, шинэ хүчин чадлыг бий болгох төсөл, үйл ажиллагаар дэмжиж ажиллана. | 2006 | Б.Жаргалсайхан |
| | | | 4. Төмрийн хүдэр, гянтболд, цайрын баяжмал болон бусад бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. | 2005-2008 | Б.Жаргалсайхан |
| | | | 5. Төсвийн хөрөнгөөр хийсэн хайгуулын ажлын зардлын хэмжээг шинэчлэн тогтоох, төсөвт нөхөн төлөх журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай асуудлыг боловсруулж, шийдвэрлэнэ. | 2005 | Б.Жаргалсайхан |
| | | | 6. Ашигт малтмалын тухай хуульд уул уурхайн үйлдвэрлэлийн алдагдлыг шилжүүлэн тооцох, хурдавчилсан элэгдэл байгуулах талаарх асуудлыг Татварын багц хуулийн шинэчлэлийн хүрээнд шийдвэрлүүлэх арга хэмжээ авна. | 2005 | Б.Жаргалсайхан |
| 181 | 3.4.21 | Газрын тосны олборлолтыг өсгөж, түүнийг боловсруулах хүчин чадлыг шинээр бий болгоно. | 1. Гэрээт болон шинээр гэрээ байгуулах талбайнуудад хийх геологи-хайгуулын болон өрөмдлөгийн ажлыг жил бүр өсгөн газрын тосны олборлолтыг 2005 онд 5.0 хувь, 2006 онд 7.0 хувь, 2007 онд 8.0 хувь, 2008 онд 9.0 хувиар тус тус нэмэгдүүлнэ. | 2005-2008 | Б.Жаргалсайхан |
| | | | 2. Зүүнбаянгийн болон Тамсагийн орд газруудыг түшиглүүлэн газрын тос боловсруулах бага оврын үйлдвэрийг байгуулах асуудлыг бодлогоор дэмжинэ. | 2005-2008 | Б.Жаргалсайхан |
| | | | 3. Газрын тосны бүтээгдэхүүний талаар хуулийн төсөл боловсруулна. | 2005 | Б.Жаргалсайхан |
| 182 | 3.4.22 | Шатдаг занар, нүүрснээс нефть бүтээгдэхүүн гаргаж авах үйл ажиллагааг дэмжинэ. | 1. Үйлдвэрлэл, технологийн парк байгуулж, хөгжүүлэх арга хэмжээний хүрээнд нүүрсний химн-технологийн судалгааны хүчин чадал бий болгох арга хэмжээ авна. | 2005-2008 | Б.Жаргалсайхан |
| | | | 2. Шатах хатуу ашигт малтмалыг гүн боловсруулах чиглэлээр баримтлах стратегийг тодорхойлж хэрэгжүүлэх ажлыг үе шаттайгаар эхлүүлнэ. | 2005-2008 | Б.Эрдэнэбат |
| 183 | 3.4.23 | Шингэрүүлсэн түлш , байгалийн хийг ахуй болон үйлдвэрлэл, тээвэрт өргөн ашиглана. | 1. Хийн салбарыг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлогыг тодорхойлж, түүнийг хэрэгжүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлнэ. | 2005-2008 | Б.Эрдэнэбат |
| | | | 2. Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг дэмжих замаар Улаанбаатар хот, бусад төв суурин газруудад ахуй, үйлдвэрлэлийн болон нийтийн тээвэр, авто машинд шингэрүүлсэн шатдаг хий ашиглах ажлыг эхлүүлнэ. | 2005-2008 | Б.Жаргалсайхан<br>Б.Эрдэнэбат |
| | | | 3. Шингэрүүлсэн шатдаг хийн туршилт, тохируулгын лаборатори байгуулах арга хэмжээ авна. | 2005-2008 | Б.Эрдэнэбат |
| | | | 4. Төв суурин газруудад барилга, орон сууцанд шингэрүүлсэн шатдаг хий ашиглах ажлын зохион байгуулалтыг шийднэ. | 2005-2008 | Б.Жаргалсайхан<br>Б.Эрдэнэбат |
| 184 | 3.4.24 | Нүүрсний уурхайнуудын техник, технологийн шинэчлэлтийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, хөдөө | 1. Төсөл хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулна. | 2005-2008 | Б.Эрдэнэбат |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | орон нутгийн нүүрсний хангамжийг сайжруулах арга хэмжээ авна. Говийн бүс, Архангай, Говь-Алтай, Завхан, Сүхбаатар, Ховд аймгийн төвийн түлшний хангамжийг сайжруулах төсөл, хөтөлбөр хэрэгжүүлнэ. | ...уурхайнуудын техник, технологийн 2. Орон нутгийн нүүрсний уурхайнуудын техник, технологийн шинэчлэлтийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, хөдөө орон нутгийн түлшний хангамжийг сайжруулах арга хэмжээ авна. | 2005-2008 | Б.Эрдэ... |
| 185 | 3.4.25 | Түлш, эрчим хүчний хэмнэлтийн эрх зүйн орчинг бий болгож, үр ашигтүй хэрэглээг багасгах, эрчим хүчний хэмнэлтийг урамшуулах эдийн засгийн механизм бий болгоно. | 1. Түлш, эрчим хүчний хэрэглээний үр ашгийг дээшлүүлэх зорилгоор түлш, эрчим хүчийг хэмнэх эрх зүйн орчинг бүрдүүлнэ. | 2005-2008 | Б.Эрдэнэбат |
| | | | 2. Барилга орон сууцны инженерийн шугам сүлжээний эрчим хүчний зүй бус алдагдлыг бууруулах төсөл боловсруулж хэрэгжүүлнэ. | 2005-2008 | Ж.Наранцацралт Б.Эрдэнэбат |
| 186 | 3.4.26 | Дэлхийн зах зээлд эрэлт хэрэгцээтэй ашигт малтмалын геологийн судалгаа, нарийвчилсан хайгуулын ажилд гадаад, дотоодын хувийн хөрөнгө оруулалтыг дэмжинэ. | 1. Улсын геологийн 1:200000-ны масштабтай зураг зохиох ажлыг үе шаттайгаар үргэлжлүүлж, улс орны эдийн засаг, бүс нутгийн хөгжлийн чиг хандлагатай уялдуулан сонгосон 300 мян.хавтгай дөрвөлжин км талбайг хамруулна. | 2004-2008 | Б.Жаргалсайхан |
| | | | 2. Монгол орны геологийн тогтоцын онцлог, ашигт малтмалын хэтийн төлөв, бүс нутгийн хөгжлийн чиг хандлагыг харгалзан сонголт хийж, нийт 80 мян. хавтгай дөрвөлжин км талбайд 1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлыг улсын төсвөөр гүйцэтгэнэ. | 2004-2008 | Б.Жаргалсайхан |
| | | | 3. Газар зүйн мэдээллийн системийг түшиглэн олон улсын мэдээллийн технологид нийцсэн "Үндэсний геомэдээллийн сан" бүрдүүлэх Засгийн газрын хөтөлбөрийг үргэлжлүүлж, сонирхогч этгээдийг өндөр нарийвчлалтай, геологийн үнэн зөв мэдээллээр шуурхай хангана. | 2004-2008 | Б.Жаргалсайхан |
| | | | 4. "Төв Азийн геологийн атлас" зохиох Орос, Казахстан, Хятад, Солонгос, Монголын хамтарсан төсөлд идэвхтэй оролцож, Төв Азийн геологи, тектоник, хатуу ашигт малтмал, шатах ашигт малтмалын зургуудыг 1:2500000-ын харьцаатай зохион 2007 онд дуусгаж, нийтийн хүртээл болгоно. | 2005-2007 | Б.Жаргалсайхан |
| | | | 5. Японы Эрчим хүчний шинэ эх үүсвэрийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх байгууллагатай дорнод говийн бүсэд төмөр замын дагуу нүүрсний нөөц баялгийг дахин үнэлгээ өгөх чиглэлээр хамтарсан судалгаа хийхэд дэмжлэг үзүүлнэ. | 2006-2008 | Б.Жаргалсайхан |
| 187 | 3.4.27 | Хөдөө орон нутагт бичил ээл олгох тогтолцоог бий болгоно. | 1. Бичил зээлийг дэмжсэн арга хэмжээ авна. | 2005-2008 | Б.Жаргалсайхан О.Чулуунбат |
| 188 | 3.4.28 | Бүс нутгийн онцлогт тохирсон бүс нутгийн хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. Бүс нутгийн хөгжил, хот байгуулалт, газар зохион байгуулалтын ажлын уялдааг хангана. | 1. Бүсийн хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлнэ. | 2005-2008 | Ж.Наранцацралт М.Энхсайхан |
| **3.5. Хөрөнгө оруулалтыг хамгаалсан найдвартай орчинг бий болгох хүрээнд:** | | | | | |
| 189 | 3.5.1 | Дотоодын үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжиж, гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлого явуулна. | 1. Монгол Улсын үйлдвэрийн хөгжлийн загварыг боловсруулах талаар судалгаа хийж, санал боловсруулна. | 2005-2008 | Б.Жаргалсайхан |
| | | | 2. Монголын аж үйлдвэрийн өрсөлдөх чадварын индексийг тодорхойлох судалгааны ажлыг НҮБ-ийн Аж үйлдвэрийн хөгжлийн байгууллагатай хамтарч хийнэ. | 2005-2008 | Б.Жаргалсайхан |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | 3. Дотоодын хөрөнгө оруулалтыг урамшуулах механизмыг бий болгоно. | 2004-2008 | Н.Баяртсайхан<br>Б.Жаргалсайхан |
| | | | 4. Гадаадын хөрөнгө оруулалтын талаарх бодлогын баримт бичгийг шинэчилж, холбогдох хуульд өөрчлөлт оруулна. | 2005-2006 | Б.Жаргалсайхан |
| | | | 5. Монголд хөрөнгө оруулагчдын чуулга уулзалтыг зохион байгуулна. | 2006 | Б.Жаргалсайхан<br>Б.Эрдэнэбат |
| | | | 6. Газар тариалан мал аж ахуйн салбарт гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих зорилгоор Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулна. | 2005-2008 | Д.Тэрбишдагва |
| 190 | 3.5.2 | Гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдад үйл ажиллагаа явуулах тодорхой, тогтвортой эрх зүйн орчинг бүрдүүлэхийн тулд олон улсын түвшинд нийцсэн, үр ашигтай нь нотлогдсон дүрэм, журам, стандартуудыг авч хэрэглэхийг дэмжинэ. | 1. Дэлхийн худалдааны байгууллагын өмнө хүлээсэн үүргийн хүрээнд хөрөнгө оруулагчдад хөрөнгө оруулалтын хэмжээг харгалзан эрх зүй, татварын ижил тэгш орчин бүрдүүлэх арга хэмжээ авна. | 2005-2006 | Б.Жаргалсайхан |
| | | | 2. Канад болон бусад улсын хот байгуулалт, газрын харилцаа, барилгын норм, норматив, техникийн баримт бичгийг судалж одоогийн мөрдөж байгаа тогтолцоог боловсронгуй болгох, зээвэрчлэх хэлбэрээс гүйцэтгэлийн шалгуурт шилжүүлэх ажлыг эхлүүлнэ. | 2005-2008 | Ж.Наранцацралт |
| 191 | 3.5.3 | Хөрөнгө оруулалтын шинэ эх үүсвэрийг дайчлах, хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх зорилгоор хөрөнгийн биржийн үйл ажиллагааг сэргээн олон улсын жишигт хүргэн ажиллуулна. | 1. Хөрөнгийн биржийн эрсдэлд оруулсан мөнгөний төлөгдөөгүй үлдэгдлийг харилцагчдад олгох асуудлыг шийдвэрлэнэ. | 2005-2006 | Н.Баяртсайхан<br>Д.Бадраа |
| | | | 2. Тэтгэвэр, даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг үнэт цаасны зах зээлд оролцуулах эрх зүйн орчинг бүрдүүлнэ. | 2005-2006 | Н.Баяртсайхан |
| | | | 3. Монгол Улсын Үнэт цаасны зах зээлийн мэргэжлийн байгууллагуудыг бэхжүүлэх чиглэлээр төсөл хэрэгжүүлэх, олон улсын байгууллагын тусламж дэмжлэг авах асуудлыг судалж хэрэгжүүлнэ. | 2005-2006 | Н.Баяртсайхан<br>Д.Бадраа |
| | | | 4. Хөрөнгийн биржийн үйл ажиллагааг олон улсын жишигт хүргэх арга хэмжээ авна. | 2005-2008 | Н.Баяртсайхан<br>Д.Бадраа |
| 192 | 3.5.4 | Дэд бүтцийн салбарт хувийн, шууд хөрөнгө оруулалтыг дэмжинэ. | 1. Түлш, эрчим хүчний салбарт хувийн шууд хөрөнгө оруулалтыг дэмжих эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилгоор холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулна. | 2005-2006 | Б.Эрдэнэбат |
| | | | 2. Түлш эрчим хүчний салбар дахь бүтцийн өөрчлөлтийг гүнзгийрүүлэн хувьчлалыг эрчимжүүлж, хувийн хэвшил хөгжих таатай орчин нөхцөлийг бүрдүүлэх замаар эдийн засгийн өсөлтийг хангана. | 2005-2008 | Б.Эрдэнэбат |
| | | | 3. Аялал жуулчлалыг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан төслүүдийг хэрэгжүүлэхэд хувийн хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжинэ. | 2005-2008 | Ц.Цэнгэл |
| | | | 4. Өөрийн орныг хөрш орнуудтай болон эдийн засгийн бүсүүдийг холбосон хэвтээ, босоо тэнхлэгийн дагуух зарим авто замыг гадаад, дотоодын хөрөнгө оруулагчаар бариулах арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, Мянганы замын хэвтээ тэнхлэгийн дагуух Хархорин-Цэцэрлэг-Тосонцэнгэл-Улиастай, Дашинчилэн-Өлийнуур, Багануур-Өндөрхаан, Хэнтий-Дорнод чиглэлд хатуу хучилттай замыг эрэн төлөгдөх нөхцөлтэйгээр барих арга хэмжээ авна. | 2005-2008 | Ц.Цэнгэл |
| **3.6. Эдийн засгийн өсөлтөд нөлөөлөхүйц дэд бүтцийг эрчимтэй хөгжүүлэх хүрээнд:** | | | | | |
| 193 | 3.6.1 | Эрчим хүч, авто зам, харилцаа холбоо, мэдээллийн нэгдсэн сүлжээг хөгжүүлэх хөтөлбөрүүдийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ. | 1. "Эрчим хүчний нэгдсэн систем", "Шингэрүүлсэн шатдаг хий" хөтөлбөрүүдийг хөдөөгийн болон бүс нутгийн хөгжилтэй уялдуулан хэрэгжүүлэх, үүнд шаардагдах хөрөнгийг жил бүрийн улсын төсөвт тусгаж хэрэгжүүлнэ. | 2004-2008 | Б.Эрдэнэбат<br>Н.Баяртсайхан |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | 2. Монгол Улсын авто замын сүлжээг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж, үе шаттай хэрэгжүүлж эхэлнэ. | 2005-2008 | Ц.Цэнгэл |
| 194 | 3.6.2 | Төмөр замын тээврийн сүлжээг өргөжүүлэн тээвэрлэх, нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх, олон улсын тээвэрт төмөр замын өрсөлдөх чадавхийг дээшлүүлнэ. Хос төмөр замтай болгох, төмөр замыг цахилгаанжуулах ажлын судалгаа хийнэ. | 1. Жил бүр 50 км-ээс доошгүй замд их засварын ажил хийж, шинээр өртөө, зөрлөг нээх, өртөөний замыг уртасгах арга хэмжээ авна. | 2005-2008 | Ц.Цэнгэл |
| | | | 2. Ачааны болон суудлын тасалгаат вагон, зүтгүүрийн паркийг шинэчилж, зүтгүүрүүдийг сүүлийн үеийн дизель хөдөлгүүрээр өөрчлөн тоноглоно. | 2005-2008 | Ц.Цэнгэл |
| | | | 3. Зүүнхараагийн вагон депод вагоны хос дугуйг эмхэтгэн эвлүүлэх цех барьж ашиглалтад оруулан, зам төмрийн элэгдлийг шавж сэргээх технологи нэвтрүүлнэ. | 2005 | Ц.Цэнгэл |
| | | | 4. Тээврийн удирдлага мэдээллийн төвийг байгуулан, вагон хайлтын системийг суурилуулна. | 2005-2006 | Ц.Цэнгэл |
| | | | 5. Багануур-Багахангай хэсэглэл зэрэг замын ачаалал ихтэй хэсгүүдэд хос төмөр зам тавих, Сүхбаатар-Замын-Үүд өртөөдийн хоорондох үндсэн төмөр замыг цахилгаанжуулах судалгааг хийнэ. | 2005-2007 | Ц.Цэнгэл |
| 195 | 3.6.3 | Таван толгой, Оюу толгой, Цагаан суварга, Асгатын болон бусад томоохон ордыг ашиглах дэд бүтцийг байгуулах ажлыг олон талын оролцоотойгоор шийдвэрлэнэ. | 1. Таван толгой, Оюу толгой, Цагаан суваргын орд болон эдгээрийн ойролцоо орших бусад ашигт малтмалын орд газруудыг цогц байдлаар ашиглах, шаардлагатай дэд бүтцийг хөгжүүлэх Үндэсний хөтөлбөр боловсруулна. | 2006-2007 | Б.Жаргалсайхан Б.Эрдэнэбат |
| | | | 2. Таван толгой, Оюу толгой, Цагаан суварга зэрэг томоохон орд газруудыг түшиглэн уулын үйлдвэр, дэд бүтцийг хөгжүүлэх төсөл бэлтгэж, эдгээр төслүүдэд төрийн оролцоог хангах талаар лиценз эзэмшигчидтэй яриа хэлэлцээ явуулах, санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэх арга хэмжээ авна. | 2006-2008 | Б.Жаргалсайхан |
| | | | 3. Асгатын мөнгөний ордыг ашиглахад шаардлагатай дэд бүтэц, уурхайн цогцолборыг байгуулах асуудлыг судална. | 2005-2008 | Б.Жаргалсайхан Б.Эрдэнэбат |
| | | | 4. Өмнөговь аймгийн нутагт үйлдвэрлэлийн цогцолбор байгуулахтай холбогдон гарах нүүрсний хэрэгцээг Тавантолгой, Нарийнсухайт болон бусад нүүрсний уурхайг өргөтгөх замаар хангах арга хэмжээ авна. | 2005-2008 | Б.Эрдэнэбат Б.Жаргалсайхан |
| 196 | 3.6.4 | 100 мвт-аас доошгүй хүчин чадалтай эрчим хүчний шинэ эх үүсвэр барьж байгуулах асуудлыг судалж санал боловсруулна. | 1. Эрчим хүчний хангамж, найдвартай ажиллагааг сайжруулах зорилгоор хэрэглээний өсөлт болон дамжуулах сүлжээний хүчин чадал, техникийн боломжтой уялдуулан шинэ эх үүсвэрийн асуудлыг судалж тодорхой санал боловсруулна. | 2005-2008 | Б.Эрдэнэбат |
| 197 | 3.6.5 | Мэдээлэл харилцааны технологи, био, нано технологийн ололтыг өргөнөөр нэвтрүүлэхэд чиглэсэн бодлого хэрэгжүүлнэ. | 1. Энэ чиглэлийн боловсон хүчнийг өндөр хөгжилтэй орнуудад сургах, дадлагажуулах, гэрээгээр ажиллуулах зэргээр үндэсний зохион бүтээх чадавхийг бий болгоно | 2005 оноос | С.Батболд Ө.Энхтүвшин |
| 198 | 3.6.6 | Монгол Улсын агаарын зайд нислэг үйлдэх олон улсын онгоцны тоог нэмэгдүүлэх, олон улсын томоохон нисэх буудал шинээр барихыг дэмжинэ. | 1. Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээнд ашиглагдах тоног төхөөрөмж, нислэгийн аюулгүй ажиллагааны хангалтыг нэмэгдүүлэн нислэгийн хөдөлгөөний төлөвлөлтийг сайжруулж Монгол Улсын агаарын зайд нислэг үйлдэх олон улсын онгоцны тоог нэмэгдүүлнэ. | 2005-2008 | Ц.Цэнгэл |
| | | | 2. Олон улсын чанартай нисэх буудлыг шинээр байгуулах судалгаа хийж, хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг эрэлхийлнэ. | 2005-2008 | Ц.Цэнгэл |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 199 | 3.6.7 | Агаарын тээврийн нэмэлт үйлчилгээ нээх асуудлыг судалж хэрэгжүүлнэ. | 1. Иргэний нисэхийн хувийн нисэгч (private pilot) бэлтгэх сургалтын баазыг бий болгох, сургалт зохион байгуулах асуудлыг шийдвэрлэх арга хэмжээ авна.<br>2. Ерөнхий нисэхийн (general aviation) үйлчилгээг дамжин ажиллах үйлчилгээг өргөжүүлнэ. | 2005-2006<br>2005-2008 | Ц.Цэнгэл<br>Ц.Цэнгэл |
| **3.7. Эдийн засгийн өсөлтийг хангахад чиглэсэн шинэ чадавхийг бий болгох зорилгоор аялал жуулчлалын болон мэдээлэл, харилцаа холбоо, технологийн хөгжлийг шинэ шатанд гаргана. Энэ зорилтын хүрээнд:** | | | | | |
| 200 | 3.7.1 | "Цахим Монгол" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. | 1. "Цахим Монгол" хөтөлбөрийг боловсруулж баталж хэрэгжүүлж эхэлнэ.<br>2. "Цахим засаглал" дэд хөтөлбөрийн мастер төлөвлөгөө боловсруулж, батална. | 2005-2008<br>2005-2006 | С.Батболд<br>С.Батболд |
| 201 | 3.7.2 | Цахим засаглалыг нэвтрүүлснээр төрөөс иргэд, байгууллагад үйлчлэх үйлчилгээг шинэ шатанд гаргах, иргэдээс төр, засаг уруу хандах мэдээллийн шинэ урсгалыг бий болгоно. | 1. Төрийн мэдээллийг иргэд, хувийн хэвшилд хүртээмжтэй, найдвартай, болгох асуудлыг үе шаттай хэрэгжүүлнэ.<br>2. Хуулийн этгээд, байгууллагын домэйн хаяг, электрон шуудангийн хаягтай болгоно. | 2005-2008<br>2005 оноос | С.Батболд<br>С.Батболд |
| 202 | 3.7.3 | Улс орны хэмжээнд нэгдмэл кодчилолыг бий болгосноор мэдээллийн нэгдсэн системийг бүрдүүлнэ. | 1. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн кодыг боловсруулж батална.<br>2. Монгол Улсад одоо хэрэглэж байгаа шуудангийн кодыг улсын хэмжээний бусад төрлийн индекс, кодуудтай харьцуулсан судалгаа хийж, тохирсон хувилбарыг сонгон хэрэгжүүлж эхэлнэ. | 2005 оноос<br>2005 оноос | С.Батболд<br>Ц.Цэнгэл<br>С.Батболд |
| 203 | 3.7.4 | Цахилгаан холбооны суурь сүлжээг шинэчлэн олон улсын өргөн зурвасын сүлжээнд нэгдэнэ. | 1. Төмөр замын шилэн кабелийг Орос, Хятадаар дамжин өнгөрч байгаа олон улсын урсгалд холбох асуудлыг судалж шийдвэрлэнэ.<br>2. Улс, хот хоорондын цахилгаан холбооны суурь сүлжээг өргөтгөн шинэчилнэ. | 2005<br>2005 оноос | Ц.Цэнгэл<br>С.Батболд<br>С.Батболд |
| 204 | 3.7.5 | Мэдээлэл, харилцаа холбооны технологийн хууль, эрх зүйн орчинг боловсронгуй болгоно. | 1. Мэдээллийн технологийн багц хууль боловсруулна. | 2005-2006 | С.Батболд |
| 205 | 3.7.6 | Эрчим хүчний байнгын эх үүсвэртэй, хүн ам төвлөрсөн газрын сургууль, айл өрхийг компьютержүүлж, интернэтийн үйлчилгээний хүрээ, хүртээмжийг өргөжүүлнэ. | 1. "Бүх нийтийн компьютержүүлэлт" хөтөлбөрийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, батална.<br>2. Интернэтийн үнийг бууруулах, үйлчилгээний хүрээг өргөжүүлэх, технологийн шинэчлэлт хийх эрх зүйн болон зохицуулалтын таатай орчинг бүрдүүлэх арга хэмжээг үе шаттайгаар авна.<br>3. Интернэт худалдаа, үйлчилгээ, зайны сургалт, цахим нийтлэл, зайны оношлогоог эрчимтэй нэвтрүүлнэ. | 2005 оноос<br>2005 оноос<br>2005-2008 | С.Батболд<br>С.Батболд<br>С.Батболд |
| 206 | 3.7.7 | Төвийн болон сэргээгдэх эрчим хүчинд холбогдсон алслагдмал сумын төв, суурин газрын мэдээлэл холбооны сүлжээний шинэчлэлтийг үе шаттайгаар хэрэгжүүлнэ. | 1. Бүс нутгийн хөгжлийн үзэл баримтлалтай уялдуулан алслагдсан сум, суурин газруудад мэдээлэл, холбооны тоног төхөөрөмжийн технологийн шинэчлэлт хийх замаар хүн амыг мэдээлэл, холбооны олон төрөлт үйлчилгээгээр хангах асуудлыг үе шаттайгаар шийдвэрлэнэ.<br>2. Шилэн кабельд холбогдсон аймгийн төв, сум, суурин газрыг интернэтэд холбох арга хэмжээ авч, статистикийн мэдээллийг сүлжээгээр авах технологид шилжүүлнэ. | 2005 оноос<br>2006-2008 | С.Батболд<br>С.Батболд<br>П.Бямбацэрэн |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 207 | 3.7.8 | Програм хангамжийн эрэлтийг нэмэгдүүлэх замаар бүтээгдэхүүний өсөлтийг дэмжинэ. | 1. Компьютер, электроник, цахилгаан холбооны тоног төхөөрөмжийн үндэсний үйлдвэрлэл болон дотоодын програм хангамжийн зах зээлийг хөгжүүлэхэд програм хангамжийн захиалга, тендерүүдийг дотоодын компаниудаар гүйцэтгүүлэх бодлогыг тулхүү баримтална. | 2005 оноос | С.Батболд |
| 208 | 3.7.9 | Томоохон суурин газруудын автомат телефон станцыг тоон технологид үе шаттай шилжүүлнэ. Улсын хэмжээнд 100 хүнд ноогдох суурин болон хөдөлгөөнт телефон хэрэглэгчдийн тоог 2008 онд дунджаар 21-д хүргэнэ. | 1. Сүүлийн үеийн мэдээлэл, холбооны технологийн давуу талуудыг нэвтрүүлэх, утасгүй холбооны технологийг түлхүү ашиглах замаар улсын хэмжээнд 100 хүнд ноогдох суурин, хөдөлгөөнт телефон хэрэглэгчдийн тоог 2008 онд дунджаар 21-д хүргэж, интернэтийн сүлжээ, түүний хамрах хүрээг нэмэгдүүлнэ. | 2005 оноос | С.Батболд |
| 209 | 3.7.10 | Интернэт худалдаа, үйлчилгээ, зайны сургалт, цахим нийтлэл, зайны оношлогоог эрчимтэй нэвтрүүлнэ. | 1. Статистикийн үндэсний мэдээллийн сан болон сар, улирал, жил тутам гаргадаг статистикийн бюллетень, танилцуулга, статистикийн эмхтгэлийг цахим хэлбэрээр гадаад, дотоодын хэрэглэгчдэд интернэтээр хүргэх үйлчилгээг нэвтрүүлнэ.<br>2. Бөөний худалдааны сүлжээний мэдээллийн сүлжээг өргөтгөх, боловсронгуй болгох замаар бөөний худалдааг сүлжээгээр гүйцэтгэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ.<br>3. Архангай, Өвөрхангай, Сэлэнгэ, Булган аймгуудын байгалийн үзэсгэлэнт газруудын судалгаа гаргаж, аялал, жуулчлал, амралтын бүс байгуулах чиглэл, төсөл боловсруулна. | 2006<br>2005-2007<br>2006-2008 | П.Бямбацэрэн<br>С.Батболд<br>ХЭЗХАБЗГ "Бөөний худалдааны сүлжээ" Б.Жаргалсайхан<br>Б.Жаргалсайхан |
| 210 | 3.7.11 | Телевизийн өргөн нэвтрүүлгийг тоон технологид шилжүүлснээр телевизийн олон сувгийг орон даяар хүлээн авах боломжийг бүрдүүлнэ. | 1. Телевизийн нэвтрүүлэг дамжуулах сувгийг тоон технологид шилжүүлж, телевизийн олон сувгийг орон даяар хүлээн авах техникийн боломжийг бүрдүүлнэ.<br>2. Улс орон даяар нэвтрүүлэх боловсролын, ялангуяа мэдээлэл, харилцаа холбооны технологийн чиглэлийн боловсрол олгох радио, телевизийн нэвтрүүлгийн сувгийг бий болгоно. | 2005 оноос<br>2006 | С.Батболд<br>Н.Баяртсайхан<br>Ө.Энхтүвшин |
| 211 | 3.7.12 | Гудамж, талбай, албан байгууллага, айл өрх бүрийг хаягжуулж, шууданг ийн бүсийн тогтолцоонд шилжүүлнэ. | 1. Газрын байршлын нэгдсэн кодтой уялдуулан хувийн болон нийтийн орон сууцанд шуудангийн хайрцгийг байрлуулах стандартыг боловсруулна.<br>2. Шуудангийн бүсчилсэн зохион байгуулалтын талаар судалгаа хийж, бүсийн тогтолцоонд шилжүүлэх арга хэмжээ авна. | 2005-2008<br>2005-2008 | Ц.Цэнгэл<br>Ж.Наранцацралт<br>Ц.Цэнгэл<br>Аймаг, нийслэлийн Засаг дарга |
| 212 | 3.7.13 | Бүх шатны шуудан хүргэлтийн тогтолцоог боловсронгуй болгож, шуудангийн зах зээлийн өрсөлдөөний зохицуулалтын механизмыг бүрдүүлэн шууданд санхүүгийн болон электрон худалдааны үйлчилгээг нэвтрүүлнэ. | 1. Бүх шатны шуудан хүргэлтийн чиглэл, маршрутын судалгаа хийж, оновчтой тогтоох санал боловсруулж хэрэгжүүлнэ.<br>2. Шуудангийн зах зээлийн өрсөлдөөнтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулах талаар Шуудангийн тухай болон бусад холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулна.<br>3. Шуудангаар санхүүгийн үйлчилгээ үзүүлэх бэлтгэлийг хангаж үе шаттайгаар нэвтрүүлэх арга хэмжээ авна.<br>4. Шуудангаар электрон худалдааны үйлчилгээ үзүүлэх бэлтгэлийг хангаж үйлчилгээг үе шаттайгаар нэвтрүүлэх арга хэмжээ авна. | 2005-2006<br>2005-2006<br>2005-2008<br>2006-2008 | Ц.Цэнгэл<br>Ц.Цэнгэл<br>Ц.Цэнгэл<br>Ц.Цэнгэл<br>Б.Жаргалсайхан |

*(Үргэлжлэл нь дараагийн дугаарт)*

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
**Хаяг: <<Төрийн мэдээлэл>>** эмхтгэлийн зөвлөл
Улаанбаатар- 12
Төрийн ордон
☎ 265958
Индекс: 14003
Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэвлэх хэсэгт хэвлэв.
☎ 329487
Хэвлэлийн хуудас 4